

**БУЛГАН АЙМГИЙН ТӨСВИЙН
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ ТӨСВИЙН
ТӨСӨЛ**

2018 ОН

АГУУЛГА

**НЭГ. МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2019 ОНЫ ХАНДЛАГА,
2020-2021 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ**

- 1.1 Гадаад худалдаа
- 1.2 Төлбөрийн тэнцэл
- 1.3 Валютын ханш
- 1.4 Инфляци
- 1.5 Зээлийн хүү бууруулах стратеги

ХОЁР. АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ЕРӨНХИЙ БАЙДАЛ

**ГУРАВ: АЙМГИЙН ТӨСВИЙН 2018 ОНЫ ЭХНИЙ 10 САРЫН ГҮЙЦЭТГЭЛ
БОЛОН ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ГҮЙЦЭТГЭЛ**

- 3.1 Аймгийн 2018 оны төсвийн 10 дугаар сарын орлогын гүйцэтгэл
- 3.2 Аймгийн 2018 оны төсвийн орлогын хүлээгдэж байгаа гүйцэтгэл
- 3.3 Аймгийн 2018 оны төсвийн нийт зарлагын эхний 10 сарын гүйцэтгэл
- 3.4 Аймгийн төсвийн зарлагын 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэл
- 3.5 Аймгийн 2018 оны төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл

ДӨРӨВ. АЙМГИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ТАНИЛЦУУЛГА

- 4.1 2018 оны төсвийн онцлог
 - 4.1.1 Төсвийн орлогын чиглэлээр
 - 4.1.2 Төсвийн зарлагын чиглэлээр
- 4.2 Аймгийн нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт

ТАВ. АЙМГИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН

- 5.1 Төсвийн орлогын төлөвлөлт
 - 5.1.1 Хувь хүний орлогын албан татвар
 - 5.1.2 Хөрөнгийн албан татвар
 - 5.1.3 Бусад татвар, төлбөр хураамж
 - 5.1.4 Татварын бус орлого
- 5.2 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгийн орлого

ЗУРГАА. ТӨСВИЙН ЗАРЛАГА

- 6.1 Орон нутгийн суурь зардал
- 6.2 Орон нутгийн хөрөнгө оруулалт
 - 6.2.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

6.2.2 Орон нутгийн хөгжлийн сан

6.2.3 Аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалт

6.2.4 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас

санхүүжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээ

6.3 Засгийн газрын тусгай зориулалтын шилжүүлэг

6.4 Орон нутгийн 2019 оны төсвийн үндсэн үзүүлэлтүүд

ДОЛОО. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИДЫН ТӨСВИЙН БАГЦ

7.1 Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн

даргын төсөв

7.2 Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын төсөв

7.3 Аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын төсөв

7.4 Аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын төсөв

7.5 Санхүүгийн хяналт аудитын албаны даргын төсөв

7.6 Хүүхдийн сувилалын даргын төсөв

7.7 Биеийн тамир спортын газрын даргын төсөв

7.8 Соёлын байгууллагуудын төсөв

НАЙМ. ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛГИЙН БАЙГУУЛЛАГЫН УРСГАЛ ТӨСВИЙН ТАНИЛЦУУЛГА

8.1 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцын төсвийн танилцуулга

8.1.1 Ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээ

8.1.2 Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ

8.2 Эрүүл мэндийн сайдын багцын төсвийн танилцуулга- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ

8.3 Хөдөлмөр, нийгмийн хамааллын сайдын багцын төсвийн танилцуулга- Гэр бүл, хүүхэд, залуучуудын үйлчилгээ

8.4 Барилга, хот байгуулалтын сайдын багцын төсвийн танилцуулга –Газрын харилцаа, геодези зураг зүй, барилга хот байгуулалтын үйлчилгээ

ЕС. ТӨСВИЙН НЭМЭЛТ ТООЦООЛЛУУД

БУЛГАН АЙМГИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

НЭГ. МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2019 ОНЫ ХАНДЛАГА, 2020-2021 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ

Монгол Улсын эдийн засгийн өсөлт эрчимжиж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хадгалах зорилгоор төсвийн алдагдлыг багасгаж, Засгийн газрын дотоод бондын хэмжээг бууруулах, улмаар хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогыг 2017-2018 онд хэрэгжүүлсэн. Хөрөнгө оруулалт, зээл олголт нэмэгдэж, бизнесийн идэвхжил сэргэсэн нь өрхийн орлогыг нэмэгдүүлж, хэрэглээг дэмжихээр байна. Гадаад орчинд тодорхой бус байдал нэмэгдэж байгаа тул Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг урт хугацааны дундаж өсөлтийн түвшинд хадгалахыг зорьж байна.

Засгийн газар эдийн засгийн өсөлтийг хангах дараах бодлогыг 2019 онд хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн.

- 1.Татварын шинэчлэлийг хэрэгжүүлж, бизнесийн орчныг сайжруулж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- 2.Төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлж, бодит салбаруудын өсөлтийг дэмжинэ.
- 3.Төрийн албан хаагчдын цалин болон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг үргэлжлүүлэн нэмэгдүүлж, иргэдийн амьжиргааг сайжруулах замаар өрхийн хэрэглээг өсгөнө.
- 4.Газрын тос боловсруулах үйлдвэр, Төв цэвэрлэх байгууламж зэрэг томоохон төслүүдийг хэрэгжүүлж, нийт эдийн засгийн потенциал хүчин чадлыг дээшлүүлнэ.

1.1 Гадаад худалдаа

Дэлхийн зах зээл дээрх зэс, цайр, төмрийн хүдэр зэрэг түүхий эдийн үнэ 2018 оны 7 дугаар сараас эхлэн буурах хандлагатай үйл явц ажиглагдаж байна. Гадаад худалдааны тэнцэл ашигтай байгаа боловч ашгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36 хувиар буурсан байна.

Хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2018 онд гадаад худалдааны нийт бараа эргэлт 13.6 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 1.3 тэрбум ам.долларын ашигтай гарахаар байна. Манай улсын экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ буурч байгаа нь экспортын хэмжээнд сөргөөр нөлөөлж байна. Экспортын зарим бүтээгдэхүүний хэмжээ өмнөх оноос нэмэгдсэн боловч үнийн бууралтаас шалтгаалан нийт экспорт 2019 онд өмнөх оны түвшнээс бага зэргийн өсөлттэй байхаар байна.

1.2. Төлбөрийн тэнцэл

Эдийн засгийн идэвхжил сэргэсэн боловч Оюутолгой төслийн далд уурхайн бүтээн байгуулалт хийгдэж байгаатай холбоотойгоор гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж, санхүүгийн данс ашигтай гарах нөхцөлийг бүрдүүлж байна.

Барааны худалдааны тэнцэл ашигтай гарч байгаа хэдий ч импортын өсөлт нь төлбөрийн тэнцлийн урсгал тэнцлийн алдагдлыг нэмэгдүүлж, валютын ханшинд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Дунд хугацаанд хөрөнгө, санхүүгийн дансны өөрчлөлтөд нөлөөлөх гол хүчин зүйлс нь гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад

үнэт цаас, Олон Улсын Валютын сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд орж ирэх төсвийн дэмжлэг зэрэг байна.

- Оюутолгой төслийн далд уурхайн бүтээн байгуулалтын хүрээнд 2019 онд 1.3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэх төлөвтэй байна.
- Олон Улсын Валютын Сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, ЖАЙКА зэрэг байгууллагуудаас төсвийн дэмжлэгт зориулсан санхүүжилт орж ирэхээр байна.

1.3. Валютын ханш

Дэлхийн томоохон төв банкууд бодлогын өөрчлөлт хийж байгаа, худалдааны хориг, тарифын асуудлуудаас үүдэлтэйгээр голлох орнуудын үйлдвэрлэл, экспорт буурахаар байгаа зэрэг нь шилжилтийн эдийн засагтай орнуудын валютын ханшинд дарамт учруулж болзошгүй байна.

2018 он гарснаар шилжилтийн эдийн засагтай орнуудын ам.доллартай харьцах ханш ихээхэн суларч байна.

1.4. Инфляци

Улсын хэмжээнд инфляцын түвшин 2015 онд 1.9 хувь, 2016 онд 1.1 хувь байсан бол эдийн засгийн өсөлтийн дүнд эрэлтийн гаралтай инфляц нэмэгдэж, 2017 онд 6.4 хувьд хүрч, 2018 оны 8 дугаар сард 6 хувь болсон байна.

Дунд хугацаанд төсөв, мөнгөний бодлогыг харилцан уялдаатай авч хэрэгжүүлснээр инфляцын түвшин 2019-2020 онд 8 орчим хувьд байхаар байна. Цаашид хүн амын худалдан авах чадвар нэмэгдэж, эрэлтийн гаралтай инфляц өсөх, газрын тосны үнэ нэмэгдэж болзошгүй тул нийлүүлэлтийн гаралтай инфляц өсөх дарамт байна. Иймд хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийг дэмжих, бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, бизнесийн зардлыг бууруулах бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1.5 Зээлийн хүү бууруулах стратеги

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2017 оны 70 дугаар тогтоолд заасны дагуу “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023” баримт бичгийг боловсруулж, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр батлуулсан. Зээлийн хүү өндөр байхад инфляц, түүнийг дагасан бодлогын хүүгийн өндөр түвшин, банкуудын эх үүсвэрийн төлөөх өрсөлдөөн, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулралт, мөнгөний нийлүүлэлтийн тогтвортой бус байдал, хөрөнгийн зах зээлийн сул хөгжил зэрэг хүчин зүйл голлон нөлөөлж байна.

Иймд, Зээлийн хүүг бууруулах стратегид үндсэн 11 бодлогын зорилтыг дараах бүлэгт хуваан, баталсан:

1. Макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлэх;
2. Мөнгөний бодлогын хүүгийн шилжих нөлөөг сайжруулах;
3. Монголбанк нь арилжааны банкуудын эрсдэл удирдах чадвар, үр ашиг, засаглалыг сайжруулах.

Энэхүү стратегийн баримт бичгийг амжилттай хэрэгжүүлснээр 2023 оны

төгсгөлд банкуудын зээлийн жигнэсэн дундаж хүү одоогийн түвшнээс 5-7 нэгж хувиар буурах буюу манай улстай ижил орлогын түвшинтэй орнуудын түвшинд хүрэхээр тооцож байна.

ХОЁР. АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ЕРӨНХИЙ БАЙДАЛ

Булган аймаг Монгол орны хойд хэсэгт байрладаг, ОХУ, Хөвсгөл, Орхон, Сэлэнгэ, Төв, Өвөрхангай, Архангай аймгуудтай хиллэдэг, ойт хээр болон тал хээр хосолсон 48.8 мянган хавтгай дөрвөлжин км нутагтай, нийт нутаг дэвсгэрийн 40 орчим хувийг шилмүүст болон навчит ой эзэлдэг бөгөөд эх газрын эрс тэс уур амьсгалтай.

Булган аймаг 16 сум, 1 тосгон, 75 багтай, суурин хүн ам 62,0 мянга, 1км²-т 1,3 хүн ногддог. Нийт хүн амын 49.2 хувийг эмэгтэйчүүд 50.8 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Нийт хүн амын 24.3 хувь нь хотод, 75.7 хувь нь хөдөөд оршин суудаг. Өрхийн тоо 19.1 мянга. Үүнээс 0.2 мянга нь хотод, 3.6 мянга нь аймгийн төвд, 4.6 мянга нь сумын төвд, 0.9 мянга нь тосгонд, 9.8 мянган нь хөдөөд амьдардаг. 1000 хүнд ногдох төрөлт 20.1, нас баралт 6.0, цэвэр өсөлт 14.1, гэрлэлт 5.9, цуцлалт 0.9, үрчлэлт 0.8 хувь байна. Хүн амын дундаж наслалт 73,2 байна.

Аймгийн хэмжээнд эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо 2017 оны байдлаар 28,2 мянга, ажиллагчдын тоо 25.9 мянга, бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1,1 мянга байгаа ба ажилгүйдлийн түвшин 8,2 хувь байгаа нь Хангайн бүсийн дунджаас 1,6 хувиар бага байна.

Төрийн албанд 3865 төрийн албан хаагч ажиллаж байна. Аж ахуйн нэгж байгууллагын дундаж цалин 638,8 мянга байна.

2018-2019 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 23 сургуульд 9.7 мянган сурагч суралцаж байгаа ба 573 багш ажиллаж, нэг багшид 17 сурагч ногдож байна. Аймгийн 23 цэцэрлэгт 121 багш ажиллаж байгаа бөгөөд цэцэрлэгт нийт 4,2 мянган хүүхэд, яслид 40 хүүхэд хүмүүжиж байна. Мөн 426 суудал бүхий 18 нийтийн номын сан ажилладаг бөгөөд уншигчдын тоо 10606 хүн байна. 3961 суудал бүхий 17 соёлын төв үйл ажиллагаа явуулж байна.

Эрүүл мэндийн салбарт 120 их эмч, 194 сувилагч, 13 эм зүйч ажиллаж байгаа бөгөөд нэг их эмчид 510, нэг сувилагчид 315 хүн ногдож байна. Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн өвчтөний тоо 12,3 мянган хүн байна. Түүнчлэн 24 спорт заалтай, биеийн тамир, спортоор хичээллэгчид 27178 хүн байна.

2017 онд 280,8 тэрбум төгрөгийн дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэснээс хөдөө аж ахуйн салбарт 50,9 хувийг, аж үйлдвэр, барилгын салбарт 23,5 хувийг, үйлчилгээний салбарт 25,7 хувийг тус тус үйлдвэрлэснийг 2016 онтой харьцуулахад 4.7 хувиар буурчээ. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 4662 мянган төгрөг болж, өмнөх онтой ижил түвшинд байна.

Иргэдийн банкуудад хадгалуулсан хадгаламжийн үлдэгдэл 38884,6 сая, зээлийн өрийн үлдэгдэл 105135,8 сая, чанаргүй зээлийн үлдэгдэл 2563,5 сая төгрөг байна.

Аймгийн бизнес регистрийн санд бүртгэлтэй 1330 аж ахуйн нэгж байгууллага байгаагаас үйл ажиллагаа явуулж байгаа нь 1186 аж ахуйн нэгж байгууллага байна.

2017 онд Булган аймагт 3361,6 мянган толгой мал тоологдсоноос адуу 261,9 мянга, хонь 1794,4 мянга, тэмээ 1.3 мянга, үхэр 283,9 мянга, ямаа 1020,1 мянга байна. Малчин өрхийн тоо 8499, малчдын тоо 14472 байна.

2017 онд 48559,2 га-д газар тариалалт хийснээс 42992 га-д үр тариа, 382 га-д төмс, 146 га-д хүнсний ногоо, 288 га-д тэжээлийн ургамал, 4496 га-д тосны ургамал, 174 га-д жимс, жимсгэнэ тарьж, 26124 тн үр тариа, 36623 тн төмс, 993.4 тн хүнсний ногоо, 796.4 тн тэжээлийн ургамал, 784 тн тосны ургамал, 20 тн жимс

жимсгэнэ хураан авсан ба нэгжийн ургац 1 га талбайгаас үр тариа 8.5 цн, төмс 95.0 цн, хүнсний ногоо 72 цн, тэжээлийн ургамал 14 цн, тосны ургамал 1.4 цн байлаа.

Техникийн үзлэгт хамрагдсан 9475 автомашин, суурин утасны тоо 613 байна. Аймгийн барилгын компаниудын гүйцэтгэсэн барилга, угсралт, их засварын ажил 2,6 тэрбум төгрөг болжээ.

Ус түгээх 50 цэг, ус тээврийн автомашин 8, зөөврийн ус хэрэглэдэг 12184 өрх, хог устгах цэг 25, хог тээврийн автомашин 27, халуун усны цэгийн тоо 27, халуун усны багтаамж 103 хүн байна.

Тус аймаг нь Хангайн бүсийн бусад аймгуудыг бодвол дэд бүтцийн хөгжил харьцангуй сайн, Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул аймагтай засмал замаар холбогдсон, төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон.

**ГУРАВ: АЙМГИЙН ТӨСВИЙН 2018 ОНЫ ЭХНИЙ 10 САРЫН ГҮЙЦЭТГЭЛ
БОЛОН ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ГҮЙЦЭТГЭЛ**

3.1. Аймгийн 2018 оны төсвийн 10 дугаар сарын орлогын гүйцэтгэл

Аймгийн төсвийн нийт урсгал орлого, тусламж шилжүүлгийн дүн 2018 оны 10 сарын байдлаар төлөвлөсөн хэмжээнээс 4.0 хувь буюу 1727.4 сая төгрөгөөр давж биеллээ.

Хүснэгт №1.2018 оны 10 сарын төсвийн орлого, тусламж шилжүүлгийн гүйцэтгэл /мян.төг/

ОРЛОГЫН ТӨРӨЛ	2017 он	2018 он			
	Гүйцэтгэл	Жилийн төлөвлөгөө	Тайлант үеийн төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	52,091,378.6	53,434,086.9	43,507,885.2	45,226,924.0	(1,719,038.8)
УРСГАЛ ОРЛОГО	21,338,793.3	20,549,449.4	16,653,935.9	18,384,894.1	(1,730,958.2)
ТАТВАРЫН ОРЛОГО	20,502,505.3	19,904,011.9	16,218,108.1	17,878,777.7	(1,660,669.6)
Орлогын албан татвар	4,595,199.4	4,937,199.8	3,803,390.1	3,416,720.2	386,669.9
Хувь хүний орлогын албан татвар	4,595,199.4	4,937,199.8	3,803,390.1	3,416,720.2	386,669.9
Хувь хүний орлогын албан татварын буцаалт	495,189.7	520,000.0	520,000.0	553,159.0	(33,159.0)
Хөрөнгийн албан татвар	719,080.5	727,110.3	616,261.1	637,921.8	(21,660.7)
Бусад татвар	15,188,225.3	14,239,701.8	11,798,456.9	13,824,135.7	(2,025,678.8)
Бусад нийтлэг төлбөр хураамж	14,284,467.1	13,436,271.3	11,191,253.1	13,337,168.2	(2,145,915.1)
Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг	136,508.5	28,700.0	15,552.0	5,757.0	9,795.0
Ус ашигласны төлбөр	13,980,957.2	13,242,370.9	11,041,950.9	13,196,488.9	(2,154,538.0)
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	74,411.5	34,500.0	30,138.5	56,810.8	(26,672.3)
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	89,827.3	130,700.4	103,611.7	78,111.5	25,500.2
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	787,513.0	623,437.5	419,327.8	481,303.9	(61,976.1)
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	48,775.0	22,000.0	16,500.0	24,812.5	(8,312.5)
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	30,801,360.3	32,906,637.5	26,870,449.3	26,866,842.4	3,606.9

Бүтцийн хувьд 2018 оны батлагдсан төлөвлөгөөг авч үзвэл татварын орлогоор 19904,0 сая буюу 37,2 хувийг, татварын бус орлогоор 623,4 сая буюу 1,2 хувийг, тусламж шилжүүлгийн орлогоор 32906,6 сая төгрөг буюу 61.6 хувийг бүрдүүлсэн байна.

3.2. Аймгийн 2018 оны төсвийн орлогын хүлээгдэж байгаа гүйцэтгэл


2018 оны аймгийн төсвийн нийт орлого, тусламжийн дүн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 54,7 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 1.3 тэрбум төгрөгөөр давж биелэхээр байна.

Хүснэгт №2. Аймгийн төсвийн урсгал орлогын хүлээгдэж буй гүйцэтгэл /мян.төг/

ОРЛОГЫН ТӨРӨЛ	2017 оны гүйцэтгэл	2018 оны төсөв	2018 оны ХБГ	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	51,940,761.1	53,434,086.9	54,693,637.5	1,259,550.6
УСРГАЛ ОРЛОГО	21,338,793.3	20,549,449.4	21,812,000.0	1,262,550.6
ТАТВАРЫН ОРЛОГО	20,502,505.3	19,904,011.9	21,218,869.6	1,314,857.7
Орлогын албан татвар	4,595,199.4	4,937,199.8	4,825,712.3	(111,487.5)
Хувь хүний орлогын албан татвар	4,595,199.4	4,937,199.8	4,825,712.3	(111,487.5)
Хувь хүний орлогын албан татварын буцаалт	495,189.7	520,000.0	553,159.0	33,159.0
Хөрөнгийн албан татвар	719,080.5	727,110.3	745,563.0	18,452.7
Бусад татвар	15,188,225.3	14,239,701.8	15,647,594.3	1,407,892.5
Улсын тэмдэгтийн хураамж	152,441.1	191,460.0	188,360.1	(3,099.9)
Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг	136,508.5	28,700.0	11,700.0	(17,000.0)
Ус ашигласны төлбөр	13,980,957.2	13,242,370.9	14,692,170.9	1,449,800.0
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	74,411.5	34,500.0	63,280.0	28,780.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	89,827.3	130,700.4	101,200.0	(29,500.4)
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	787,513.0	623,437.5	568,130.4	(55,307.1)
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	48,775.0	22,000.0	25,000.0	3,000.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	30,650,742.80	32,906,637.5	32,906,637.5	

Энэ оны эцсээр татварын орлого 21218,9 сая төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 1314,9 сая төгрөг буюу 6.6 хувиар өсөх бол татварын бус орлого 568,1 сая болж, төлөвлөснөөс 55,3 сая төгрөг буюу 8.9 хувиар тасрахаар байна. Нийт дүнгээрээ орлого, тусламжийн дү өмнөх оны гүйцэтгэлээс 5.2 хувь буюу 2.7 тэрбум төгрөгөөр өсөх тооцоо гарлаа.

Зураг №1. Төсвийн орлогын гүйцэтгэл 2014-2018* он /сая.төг/



3.3 Аймгийн 2018 оны төсвийн нийт зарлагын эхний 10 сарын гүйцэтгэл

Аймгийн төсвийн нийт зардал 2018 оны 10 дугаар сарын байдлаар 51,1 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 44,5 тэрбум төгрөгийн буюу 87,1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №3. Төсвийн зарлагын эхний 10 дугаар сарын гүйцэтгэл, төсвийн бүрэлдэхүүнээр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Нэгдсэн төсөв	Аймгийн төсөв	Сумдын төсөв	ТЗШ-ийн төсөв
Жилийн төлөвлөгөө	59,850.2	18,780.2	10,475.6	30,594.4
Төлөвлөгөө /10 сарын өссөн дүнгээр/	51,060.4	17,059.4	9,050.9	24,950.1
Гүйцэтгэл	44,476.9	13,824.7	7,245.3	23,406.9
Хувь	87.1	81.0	80.1	93.8

Аймгийн төсвийн зарлага 13,8 тэрбум буюу 81.0 хувь, сумын төсвийн зарлага 7,2 тэрбум буюу 80.1 хувь, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага 23,4 тэрбум төгрөгийн буюу 93,8 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.4 Аймгийн төсвийн зарлагын 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэл

Орон нутгийн төсвийн зардал 56,8 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөө 5,0 хувиар хэмнэгдэх төлөвтэй байна.

Хүснэгт №4. Төсвийн зардлын гүйцэтгэл 2012-2018* он /сая.төг/

Зардлын зүйл	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 оны		
						төлөв	ХБГ	хувь
I.Нийт зардал	44,275.4	48,508.9	50,902.6	50,276.0	53,946.5	59,850.2	56,802.8	94.9
II.Урсгал зардал	40,980.1	42,579.3	38,898.3	41,099.5	48,716.8	51,885.2	48,946.4	94.3
Бараа үйлчилгээний зардал	35,846.5	36,359.8	33,019.5	34,720.0	39,801.5	45,022.0	42,083.2	93.5
Татаас ба урсгал шилжүүлэг	5,133.6	6,219.5	5,878.8	6,379.5	8,915.3	6,863.2	6,863.2	100.0
III.Хөрөнгийн зардал	3,295.3	5,929.6	12,004.3	9,176.5	5,229.7	7,965.1	7,856.4	98.6

Төсвийн зардлын бүтцийг авч үзвэл урсгал зардалд 86.1%-ийг зарцуулсан ба үүнээс бараа үйлчилгээний бусад зардалд 74.1%, татаас ба урсгал шилжүүлэгт 11.9% хөрөнгийн зардалд 13,7%-ийг тус тус зарцуулжээ. /2018 оны ХБГ-р тооцсон./ Энэ оны 4 дүгээр улиралд дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

1.Орон нутгийн төсвийн байгууллагууд, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад үүссэн өр төлбөрийг дарах

2.Төсвийн зарлагын хүлээгдэж буй гүйцэтгэл, хэрэгцээнд нийцүүлэн төсвийн хуваарьт өөрчлөлт хийх байдлаар зарим зохицуулалтыг хийх зэрэг болно.

3.5 Аймгийн 2018 оны төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл

2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 80 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, 9,4 тэрбум төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөж, 15 төсөл арга хэмжээг холбогдох хуулийн дагуу харьяалах сумдын Засаг даргын тамгын газарт тендер зохион байгуулах эрх шилжүүлж, үлдсэн 65 төсөл арга хэмжээний худалдах авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулахаар төлөвлөснөөс 58 төсөл арга хэмжээг “Цахим-2” системээр зохион байгуулсан. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 91,2 хувьтай байна.

Зураг төсөвгүй хөрөнгө баталдаг, тендер шалгаруулалттай холбогдуулан оролцогч компаниуд гомдол гаргадаг, мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн зураг төсвийн үнээс бага хөрөнгө баталдаг тул батлагдсан хөрөнгөнд тааруулж дахин зураг төсөв хийлгэх, эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээнүүдийн тендер шалгаруулалт зохион байгуулагдахгүй удааширдаг, хэт бага төсөв, валютын ханшийн өсөлт, нарийн мэргэжил, техник, тоног төхөөрөмж шаардсан төсөл арга хэмжээнд оролцогч оролцдоггүй зэрэг шалтгааны улмаас төлөвлөгөөт төсөл арга хэмжээнүүдийн тендер шалгаруулалт хугацаандаа зохион байгуулагдахгүй байна.

Аймгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэлийг дараах байдлаар үзүүлж байна.

Хүснэгт №5. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт /сая.төг/

2018-11-15-ны байдлаар

Үзүүлэлт	Нийт батлагдсан	Нийт санхүүжсэн	Гүйцэтгэлийн хувь	Үлдэгдэл санхүүжилт
Орон нутгийн хөрөнгө оруулалт	2,713.2	2,447.8	90.2	265.4
Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт	860.4	512.9	59.6	347.5
Орон нутгийн авто замын сангийн хөрөнгө оруулалт	391.6	329.4	84.1	62.2
Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалт	4,641.3	2,938.7	63.3	1,702.6
ДҮН	8,606.5	6,228.8	74.3	2,377.7

Аймаг, сумын төсвөөс санхүүжүүлэхээр 8,6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт баталж, 6,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлж, санхүүжилтийн гүйцэтгэл 74.3 хувьтай байна. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг эх үүсвэрээр нь хөтөлбөр төсөл арга хэмжээ бүрээр толилуулж байна.

Хүснэгт №6. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл /сая.төг/

2018-11-15-ны байдлаар

д/д	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	2018 онд санхүүжүүлэхээр батлагдсан	Санхүүжилт	Үлдэгдэл	Хувь
1	Сайхан сумын сургуулийн дотуур байр, 160 сурагчдын хоолны газар /Концессын гэрээний дагуу 2017 онд 300.0 сая төгрөг 2018 онд 251.0 сая төгрөг/	251,000.0	251,000.0	-	100.0

2	Аймгийн баяр наадмын талбайг шинэчлэн засварлах	252,845.0	194,146.4	58,698.6	76.8
3	Булган сумын төвийн гэрэлтүүлгийн өргөтгөл, шинэчлэлийн ажил	477,101.0	436,018.6	41,082.4	91.4
4	Булган сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэлийн ажил	52,013.6	50,291.8	1,721.8	96.7
5	Аймгийн ЗДТГ-ын суудлын автомашин	50,000.0	50,000.0	-	100.0
6	Сумдын ЗДТГ-ын суудлын автомашиныг шинэчлэх /Бугат, Булган, Гурванбулаг, Сэлэнгэ, Хутаг-Өндөр/	250,000.0	249,950.0	50.0	100.0
7	Шүүхийн шинжилгээний албаны тусгай зориулалтын автомашин	40,000.0	38,875.0	1,125.0	97.2
8	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны яаралтай тусламжийн иж бүрдэл тоног төхөөрөмж	5,000.0	5,000.0	-	100.0
9	Булган сумын 5 дугаар байрны орчин нөхцөл, өнгө үзэмжийг нь сайжруулах	55,000.0	51,239.6	3,760.4	93.2
10	Булган сумын 6 дугаар байрны орчин нөхцөл, өнгө үзэмжийг нь сайжруулах	53,000.0	49,406.9	3,593.1	93.2
11	Булган сумын 7 дугаар байрны орчин нөхцөл, өнгө үзэмжийг нь сайжруулах	53,000.0	50,496.1	2,503.9	95.3
12	Булган сумын 22 дугаар байрны орчин нөхцөл, өнгө үзэмжийг нь сайжруулах	79,000.0	65,024.6	13,975.4	82.3
13	2017 онд хэрэгжсэн барилга байгууламжийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах ажлын дутуу санхүүжилт, 2018 онд хэрэгжүүлэх барилга байгууламж ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах ажил	197,665.1	125,223.4	72,441.7	63.4
14	Булган сумын 3 дугаар багийн А-Б хэсгийн хоорондох 0,55 км хатуу хучилттай авто зам	322,300.0	282,100.8	40,199.2	87.5
15	Ачуут голын явган хүний гүүрийг шинэчлэх /Булган сум/	20,000.0	19,200.0	800.0	96.0
16	Соёл, спортын цогцолбор байгуулах /Сэлэнгэ сум/	100,000.0	100,000.0	-	100.0
17	Сургуулийн дотуур байрны их засвар /Гурванбулаг сум/	124,300.0	118,699.0	5,601.0	95.5
18	Сэлэнгэ мөрний төмөр бетон гүүрийн засвар /Хангал сумын Хялганат тосгон/	77,000.0	73,629.8	3,370.2	95.6
19	Сансар 1, 2 цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт /Булган сум/	34,000.0	33,428.4	571.6	98.3
20	Хэмжих хэрэгслийн эталон тоног төхөөрөмж	48,000.0	47,860.0	140.0	99.7
21	Аймгийн Музейн барилгын их засвар	72,000.0	69,747.5	2,252.5	96.9
22	Дулааны станцыг ашиглалтад оруулахтай холбогдуулан Ус дулаан дамжуулах төвийн II хэлхээг холбох болон цахилгаан хангамжийг шийдвэрлэх	100,000.0	86,471.2	13,528.8	86.5
Нийт дүн		2,713,224.7	2,447,809.2	265,415.5	90.2

Хүснэгт №7. Орон нутгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл /сая.төг/
2018-11-15-ны байдлаар

Д/д	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	2018 онд санхүүжих	Нийт санхүүжсэн	Үлдэгдэл	Хувь
1	Ахмадын амралтын замын засвар /Булган сум/	50,000.00	40,046.5	9,953.5	80.1
2	Булган сумын 23 дугаар байрны зүүн тал, эрүүл мэндийн төвийн хойд талд зогсоолын талбай байгуулах /2ш/	64,150.00	62,905.9	1,244.1	98.1
3	Булган сумын 9-р байрны баруун тал, хуучин халуун усны газар, Хүний хөгжлийн төв, МСҮТ-ийн замын хойд талд зогсоолын талбай байгуулах /4ш/	71,830.00	71,830.0	0.0	100.0
4	Булган сумын төрөх эмнэлгийн хойд тал, ЭӨЦСургууль, 2-р цэцэрлэгийн урд талд зогсоолын талбай байгуулах /3ш/	64,150.00	63,102.2	1,047.8	98.4
5	Булган сумын авто зогсоолын талбайн дуусгал	39,470.00	39,470.0	0.0	100.0
6	Байгалийн гамшгийн үеийн авто зам, замын байгууламжийн засвар	15,000.00	2,000.0	13,000.0	13.3
7	Булган сумын авто замын засвар, арчлалт	30,000.00	30,000.0	0.0	100.0
8	Зам, тээврийн хяналтын төвийн зардал	12,000.00	4,617.0	7,383.0	38.5
9	Зохиогчийн хяналтын болон зураг төсвийн зардал	30,000.00	1,074.7	28,925.3	3.6
10	Цагаан голын гүүрийн засвар шинэчлэлт /Баян-Агт сум/	15,000.00	15,000.0	0.0	100.0
Нийт дүн		391,600.00	330,046.3	61,553.7	84.3

Хүснэгт №8. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл /сая.төг/
2018-11-15-ны байдлаар

д/д	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	2018 онд санхүүжүү лэхээр батлагдсан	Санхүүжилт	Үлдэгдэл	Хувь
1	Сайхан, Тэшиг сумын сургуулийн ариун цэврийн байгууламжийн засвар /БСШУЯ, Дэлхийн зөн ОУБ, Мобиком корпорацийн хөрөнгөөр хэрэгжих төслийн орон нутгийн оролцоо/	50,000.0	-	50,000.0	0.0
2	Спортын ордны урд талаас Нэгдсэн эмнэлгийн арын уулзвар хүртэлх 0.453 км авто зам	267,689.2	165,379.5	102,309.7	61.8
3	Жаргалантын амны зуслангийн цахилгаан хангамж /Булган сум/	20,000.0	19,981.7	18.3	99.9
4	Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн автомашин	35,000.0	34,900.0	100.0	99.7
5	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийг шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангах	70,000.0	67,474.6	2,525.4	96.4
6	Анхдагч алдартны ордны гэрэлтүүлэг, агааржуулалтын тоног төхөөрөмж /Булган сум/	15,000.0	15,000.0	-	100.0
7	Цагдаагийн газрын жижүүрийн шуурхай албаны дуудлагын фургон автомашин /тусгай тоноглол бүхий/	38,000.0	38,000.0	-	100.0
8	Нярайн эндэгдлийг бууруулах сурфактант эмчилгээний тоног төхөөрөмж	48,000.0	-	48,000.0	0.0

9	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын их танхимыг үзэгчдийн суудал, тоног төхөөрөмжөөр хангах	50,000.0	45,800.0	4,200.0	91.6
10	Булган сумын ЭӨЦС-ийн ариун цэврийн байгууламжийн засвар /Герман улсын хөрөнгөөр хэрэгжих төслийн орон нутгийн оролцоо/	40,000.0	-	40,000.0	0.0
11	Гэрч хохирогчийг хамгаалах байрыг стандартын дагуу тохижуулах	15,400.0	15,000.0	400.0	97.4
12	Аймгийн баяр наадмыг тэмдэглэх	50,000.0	49,983.5	16.5	100.0
13	Техник технологи, инноваци нутагшуулах, үйлдвэрлэлийн бүсийн үйл ажиллагааны ТЭЗҮ боловсруулах	98,000.0	-	98,000.0	0.0
14	Аймгийн Музейн үзмэр дэглэлт	32,300.0	30,426.7	1,873.4	94.2
15	Сэлэнгэ сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө	31,000.0	31,000.0	-	100.0
Нийт дүн		860,389.2	512,945.8	347,443.4	59.6

Хүснэгт №9. Сумдад олгох орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийн гүйцэтгэл /сая.төг/

2018-11-15-ны байдлаар

№	Сумдын нэрс	2018 оны төлөвлөгөө	Нийт санхүүжсэн	Хувь
1	Баян-Агт	59.5	56.7	95.3
2	Баяннуур	33.8	30.4	90.0
3	Бугат	34.9	29.6	84.7
4	Булган	79.2	72.3	91.3
5	Бүрэгхангай	48.8	40.0	82.1
6	Гурванбулаг	56.6	45.0	79.4
7	Дашинчилэн	52.1	41.9	80.5
8	Могод	49.3	40.6	82.4
9	Орхон	47.8	35.2	73.7
10	Рашаант	58.4	46.1	79.0
11	Сайхан	52.8	41.2	78.0
12	Сэлэнгэ	65.4	38.5	58.8
13	Тэшиг	108.1	86.8	80.3
14	Хангал	31.3	28.2	90.2
15	Хялганат	31.3	28.2	90.2
16	Хишиг-Өндөр	44.7	39.7	88.8
17	Хутаг-Өндөр	94.8	68.2	71.9
	Дүн	948.8	768.7	81.0

Хүснэгт №10. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний гүйцэтгэл /сая.төг/

2018-11-15-ны байдлаар

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил, хүчин чадал	2018 онд санхүүжих	Нийт санхүүжсэн	Үлдэгдэл	Хувь
Нэг. Ой, цөлжилтийн талаар:					
1	Ойжуулалт /Бугат, Могод, Сэлэнгэ, Хангал /300 га/	208,500.0	101,909.6	106,590.4	48.9
2	2016 оны үлдэгдэл ойжуулалт /Бүрэгхангай, Орхон, Хангал, 300 га/	51,700.0	-	51,700.0	0.0
3	Ойн хортны тэмцлийн ажил /Баян-агт, Бүрэгхангай, Орхон, Сэлэнгэ, Тэшиг, Хангал, Хутаг-Өндөр, 26000 га/	383,109.9	372,748.3	10,361.6	97.3

4	Ойн хортны судалгааны ажил /500000 га/	50,000.0	25,199.7	24,800.3	50.4
5	Арчилгааны огтлолт хийх /80га/	9,600.0	8,400.0	1,200.0	87.5
6	Ойн нөхөрлөлүүдийн ойн санд ой зохион байгуулалт хийлгэх /40 ойн нөхөрлөл/	56,000.0	-	56,000.0	0.0
7	Ойн нөхөрлөлүүдийг идэвхжүүлэх зорилгоор нөхөрлөлийн ойн санд хортонтой гэрлэн урхиар тэмцэх /2000 га/	10,000.0	8,000.0	2,000.0	80.0
8	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалт /2 удаа/	8,000.0	5,360.7	2,639.3	67.0
9	Хутаг-Өндөр, Булган суман дахь сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газрыг өргөтгөх	15,000.0	10,500.0	4,500.0	70.0
10	Үлийн цагаан оготны устгал /Гурванбулаг, Дашинчилэн, Могод, Сайхан, Рашаант, Хишиг-Өндөр, 120000 га/	100,000.0	-	100,000.0	0.0
11	Байнгын үрийн талбай арчлах /3 ойн анги, 20 га/	18,000.0	13,090.0	4,910.0	72.7
12	Ой хээрийн түймрээс хамгаалах шороон зурвас байгуулах /Сэлэнгэ, Тэшиг, Хутаг-Өндөр, 130 га/	30,000.0	-	30,000.0	0.0
13	Булган хотын нийтийн эзэмшлийн зам, талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэцэрлэгжүүлэх	177,000.0	139,527.8	37,472.2	78.8
14	"Булган жимс жимсгэнэ" хөтөлбөр хэрэгжүүлэх	370,000.0	119,602.8	250,397.2	32.3
15	Шахмал түлшний үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралт, туршилтын үйл ажиллагааны зардал /2016 оны гэрээний үлдэгдэл/	12,940.0	12,940.0	-	100.0
Дүн		1,499,849.9	817,279.0	682,570.9	54.5
Хоёр. Усны нөөцийг хамгаалах, усан хангамжийг сайжруулах талаар					
16	Хүн ам, бэлчээрийн усан хангамжид зориулж шинээр худаг гаргах /20 ш/	360,000.0	306,179.2	53,820.8	85.0
17	Булаг шандын эхийг хашиж хамгаалах /10 булаг/	41,200.0	3,542.2	37,657.8	8.6
18	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн зааг, тэжээгдлийн мужийг тэмдэгжүүлэх /200 ш/	26,000.0	26,000.0	-	100.0
19	Хөв цөөрөм байгуулах /Дашинчилэн, Могод, Сайхан, Рашаант/	298,600.0	155,122.4	143,477.6	51.9
20	Сайхан сумын Ундрах нуурыг сэргээх	15,000.0	15,000.0	-	100.0
21	Баян-Агт сумын Цэгээн, Хагийн нуур, Баяннуур сумын Баян нуур, Хишиг-Өндөр сумын Хонхор нуур, Могод сумын Загаст нуурыг сэргээх судалгааны ажил хийлгэх	15,000.0	-	15,000.0	0.0
22	Баян-Агт сумын Баян, Баяннуур сумын Дал, Булган сумын Ачуут голын эхийг хашиж хамгаалах судалгаа, зураг, төсөл боловсруулах	7,200.0	-	7,200.0	0.0
23	Гурванбулаг сумын Мойлтын ам, Рашаант сумын Их аргал уулын өвөрт хөв цөөрөм байгуулах зураг, төсөл боловсруулах	15,000.0	-	15,000.0	0.0
24	Орхон голын Зүр хүзүүний гарамд гатлага онгоц тавих	110,000.0	83,189.7	26,810.3	75.6
25	Усны тоо бүртгэл, судалгааны ажлыг зохион байгуулах	50,000.0	50,000.0	-	100.0
26	Хануйн голын сав газрын захиргааны тоног төхөөрөмж /жагсаалтаар/	10,000.0	9,825.7	174.3	98.3

27	Цэвэр усны шугам, даралтад цамхагийн өргөтгөл шинэчлэлийн ажлын дуусгал /Хангал сум Хялганат тосгон/	107,700.0	70,824.0	36,876.0	65.8
28	Рашаант сумын цэвэрлэх байгууламж	140,000.0	-	140,000.0	0.0
29	Булган сумын үерийн сувгийн даланг шинэчлэн засварлах	78,806.6	-	78,806.6	0.0
30	Булган хотын ундны эх үүсвэрийг стандартын дагуу хашиж, хамгаалах	80,000.0	74,890.1	5,109.9	93.6
31	Булган сумын үерийн сувгийн даланг шинэчлэн засварлах	76,400.0	44,684.8	31,715.2	58.5
Дүн		1,430,906.6	839,258.1	591,648.5	58.7
Гурав. Газар, газрын хэвлийг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах, хог хаягдлыг багасгах талаар					
32	Булган сумын Зүүн түрүүний гэр хорооллын айл өрхөд хог төрөлжүүлэн хийх хогийн сав нийлүүлэх /170 ш/	76,510.0	76,510.0	-	100.0
33	Булган сумын Домын дэвсэг, 6д хэсгийн гэр хорооллын айл өрхөд хог төрөлжүүлэн хийх хогийн сав нийлүүлэх /170 ш/	76,510.0	75,791.6	718.4	99.1
34	Булган сумын 5-р багийн гэр хорооллын айл өрхөд хог төрөлжүүлэн хийх хогийн сав нийлүүлэх /170 ш/	76,510.0	76,006.8	503.2	99.3
35	Булган сумын 2в, 2б, 3а хэсгийн гэр хорооллын айл өрхөд хог төрөлжүүлэн хийх хогийн сав нийлүүлэх /170 ш/	76,510.0	76,510.0	-	100.0
36	Булган сумын 6а хэсгийн гэр хорооллын айл өрхөд хог төрөлжүүлэн хийх хогийн сав нийлүүлэх /170 ш/	76,510.0	72,472.3	4,037.7	94.7
37	Булган сумын 3б, 3в хэсгийн гэр хорооллын айл өрхөд хог төрөлжүүлэн хийх хогийн сав нийлүүлэх /175 ш/	78,750.0	75,604.4	3,145.6	96.0
38	Ерөнхий боловсролын сургуулиудын дунд "ЭКО" сургууль болзолт уралдаан зохион байгуулах	3,500.0	3,500.0	-	100.0
39	Булган сумын төвлөрсөн хогийн цэгт ландшафлийн ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай бага оврын гинжит экскаватор трактор нийлүүлэх	85,000.0	-	85,000.0	0.0
40	Булган сумын оршуулгын газар "Цэцэг толгой"-г хашаажуулах зураг төсөв хийлгэх	15,000.0	14,388.5	611.5	95.9
41	Булган суманд хог ачих зориулалттай 5 тн-ын өөрөө буулгагч автомашин нийлүүлэх /2 ш/	80,000.0	-	80,000.0	0.0
42	Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнд нийтийн бие засах газар барих /1 ш/ Булган сум	68,000.0	64,436.9	3,563.1	94.8
43	Нүхэн жорлон хүн амын ундны эх үүсвэрийн худагт нөлөөлж буй эсэх судалгааг хийж, орчны бохирдлыг тодорхойлох	10,000.0	8,000.0	2,000.0	80.0
44	Эвдэрсэн газрын тооллогын ажлыг зохион байгуулах	20,000.0	11,918.8	8,081.2	59.6
45	Ургамлан бүрхэцийн зураг авалт хийж ургац болон даацыг тодорхойлох мониторинг хийх	4,800.0	4,799.8	0.2	100.0
46	Авто зам дагуух газруудад хаягийн самбар байршуулах	23,170.0	15,400.0	7,770.0	66.5
47	Цэвэр орчин аяныг зохион байгуулах /15 сум 1 тосгон/	48,000.0	44,649.8	3,350.2	93.0

48	Аймгийн Соёл, амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлыг ерөнхий төлөвлөгөөний дагуу шат дараатайгаар хийж гүйцэтгэх	180,000.0	147,313.9	32,686.1	81.8
Дүн		998,770.0	768,302.8	230,467.2	76.9
Дөрөв. Хөрс, ус, агаарын судалгаа шинжилгээний талаар					
49	Цаг агаарт нөлөөлөх ажилд дэмжлэг үзүүлэх	5,000.0	5,000.0	-	100.0
50	Цаг уурын ажиглалтын хашааг томсгож, цахилгаан татах	25,100.0	23,919.4	1,180.6	95.3
Дүн		30,100.0	28,919.4	1,180.6	96.1
Тав. Биологийн төрөл зүйлийг хамгаалах					
51	Тусгай хамгаалалттай газар нутагт биотехникийн арга хэмжээ авах /Зэд-Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газар, Хөгнө-Тарны тусгай хамгаалалттай газар/	6,000.0	3,000.0	3,000.0	50.0
52	Улсын болон орон нутгийн хамгаалалтад авсан газар нутгийн хамгаалалтын дэглэмийг мөрдүүлэн хилийн заагийн тэмдэг тэмдэглэгээ хийх, мэдээллийн самбар байрлуулах, хашиж хамгаалах, тэмдэгжүүлэх /Баян-Агт, Бугат, Могод, Сайхан, Сэлэнгэ, Хутаг-Өндөр/	12,000.0	-	12,000.0	0.0
53	Ховор ургамал болох "Заан хүж"-ийг хамгаалах /Баян-Агт сум/	5,000.0	5,000.0	-	100.0
Дүн		23,000.0	8,000.0	15,000.0	34.8
Зургаа. Аялал жуулчлалын талаар					
54	Мэргэжлийн байгууллагатай хамтран аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулан гаргах	26,000.0	-	26,000.0	0.0
55	Аялал жуулчлалын зөвлөгөөн, үзэсгэлэн зохион байгуулах	4,500.0	3,953.0	547.0	87.8
56	Аймгийн байгаль, түүх, соёлын аялал жуулчлалыг сурталчлах /альбом гаргах, нэвтрүүлэг бэлтгэх, CD гаргах, зурагт самбарын мэдээллийг шинэчлэх/	70,000.0	57,525.0	12,475.0	82.2
57	Аялал жуулчлалын цогцолбор байгуулах /Булган сум/	250,000.0	216,579.7	33,420.3	86.6
58	Эвент арга хэмжээ зохион байгуулж гадаад дотоодын жуулчдад сурталчлах	50,000.0	9,341.5	40,658.5	18.7
59	Байгаль орчинд сөрөг нөлөөгүй үйл ажиллагаа эрхлэгч "Эко" иргэн, аж ахуйн нэгж шалгаруулж урамшуулах	3,000.0	-	3,000.0	0.0
60	"International tourism mongolia-2018", "Улаанбаатар тур-2018 "ITB-2018" дотоодын болон олон улсын үзэсгэлэнд оролцох	16,000.0	6,260.5	9,739.5	39.1
61	Орхон сумын тусгай хамгаалалттай "Сээрийн буган чулуун цогцолбор"-ыг хашиж, хамгаалах	25,000.0	22,664.2	2,335.8	90.7
62	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газруудыг тэмдэгжүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох /Баян-Агт, Булган, Сайхан/	8,000.0	5,764.3	2,235.7	72.1
Дүн		452,500.0	322,088.2	130,411.8	71.2
Долоо. Хяналт шалгалт					
63	Ус, рашааны нөөцийн ашиглалт, төлбөрийн орлогын гүйцэтгэлд хяналт шалгалт хийх	6,000.0	898.4	5,101.6	15.0
64	Хууль бус мод бэлтгэл, ангийн зөрчлийг таслан зогсоох, байгаль орчны багц хуулийг хэрэгжүүлэх зорилгоор хяналт шалгалт хийх /улиралд 1 удаа 3 чиглэлд/	30,000.0	13,895.9	16,104.1	46.3

65	Ой, хээрийн түймрээс хамгаалах багаж тоног төхөөрөмжөөр хангах	25,000.0	24,480.0	520.0	97.9
66	Ой, хээрийн хуурайшилтын үед морин эргүүл, явуулын хяналт тавих /6 суманд 2 удаа/	11,500.0	1,920.0	9,580.0	16.7
67	Бугат, Бүрэгхангай суманд Байгаль хамгаалагч ажиллуулж, урамшуулах	12,000.0	5,697.0	6,303.0	47.5
68	Дархан цаазат газар болох Эг-Тарвагатайн бэлчирт хяналтын камер байруулах	12,000.0	-	12,000.0	0.0
Дүн		96,500.0	46,891.3	49,608.7	48.6
Найм. Мэдээлэл, сургалт, сурталчилгааны талаар					
69	Байгаль хамгаалах чиглэлээр сурталчилгааны самбар хийлгэх /16 сум/	16,000.0	15,746.4	253.6	98.4
70	Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан иргэдэд зориулсан сургалт сурталчилгаа хийх, эко уралдаан зохион байгуулах /5 удаа/	5,000.0	4,477.5	522.5	89.6
71	Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах болон өрхийн усан хангамж, эрүүл ахуйн талаар иргэдэд зориулсан сургалт зохион байгуулах	8,700.0	6,160.0	2,540.0	70.8
72	Байгаль орчны бодлого, статистик мэдээллийн ном хэвлүүлэх	15,000.0	13,700.0	1,300.0	91.3
73	Ойн нөхөрлөлүүд, багийн дарга нар, малчид, иргэдэд зориулсан чадавхижуулах болон бэлчээрийн менежментийн талаар сургалт, зөвлөгөөн зохион байгуулах	50,000.0	50,000.0	0.0	100.0
74	Сумдын төвийн байгаль хамгаалагчдыг компьютерээр хангах /12 ш/	10,000.0	9,998.1	1.9	100.0
75	Байгаль хамгаалах сангийн үйл ажиллагааны зардал	5,000.0	3,149.9	1,850.1	63.0
Дүн		109,700.0	107,962.4	1,737.6	98.4
Нийт дүн		4,641,326.5	2,938,701.1	1,702,625.4	63.3

ДӨРӨВ. АЙМГИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ТАНИЛЦУУЛГА

4.1. 2019 оны төсвийн онцлог

Аймгийн 2019 оны төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан төсвийн зарчмууд, Сангийн яамнаас хүргүүлсэн 2019 оны төсвийн төслийг боловсруулахад баримтлах чиглэл, удирдамж% хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн орчин, заавар журмын хүрээнд боловсрууллаа.

Төсвийн урсгал зарлагын реформыг хэрэгжүүлж төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардагдах зардлыг тусгаж өгсөн нь онцлог болсон.

4.1.1 Төсвийн орлогын чиглэлээр:

1. Төсвийн орлогод учирч болзошгүй эрсдэлийг тооцон, төсвийн орлогыг бодитойгоор төсөөлж, боломжит эх үүсвэрийг дайчлан, төсвийн орлогын бааз суурийг нэмэгдүүлэх

2. Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого төвлөрүүлэлтэд хяналт тавьж, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкнаас хадгаламж зэмшигчдийн мэдээллийг тогтмол авч орлого төвлөрүүлэлтэд анхаарах

3. Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, үнийн өсөлтийн түвшин зэрэгтэй уялдуулан 2019 онд “Хувь хүний орлогын албан татварын тухай хууль”-ийн 24.1-т заасны дагуу тооцохоор төлөвлөсөн.

4. 2019 оноос хэрэгжиж эхлэх Татварын хуулийн шинэчлэлийг орон нутагт хурдан шуурхай, үр дүнтэй сурталчилан таниулж биелэлтийг хангуулах.

4.1.2 Төсвийн зарлагын чиглэлээр:

а/ Орон нутгийн хөрөнгө оруулалтын чиглэлээр

Орон нутгийн хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр орон нутгийн чиг үүрэгт хамааралтай тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн шаардлагатай хөрөнгө оруулалтын зардлыг тооцож 1,1 тэрбум төгрөгөөр тусгав.

б/Орон нутгийн хөгжлийн сан

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээ өмнөх оны түвшнээс 56,5 хувиар нэмэгдэж 3,6 тэрбум төгрөг болсон.

Сангийн яам, Дэлхийн банкны хамтран хэрэгжүүлж буй Тогтвортой Амьжиргаа-3 төслийн хүрээнд 2019 онд орон нутгийн хөгжлийн сангийн төсвийг дэмжих дэмжлэг 343,8 сая төгрөг, сайн гүйцэтгэлийг урамшуулах зорилгоор зургаан сумын орон нутгийн хөгжлийн санд 84,5 сая төгрөгийн урамшуулал нийт 427,8 сая төгрөг олгосон байна. Мөн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй нэр бүхий 10 суманд 1,8-68,7 сая нийт 222,7 сая төгрөгийн орлогын шилжүүлэг хувиарлагдсан нь аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан нийт хөрөнгөд багтаж байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн санд хуваарилагдсан хөрөнгийг сумын орон нутгийн хөгжлийн санд хуваарилахдаа Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор

шинэчлэн батлагдсан “Орон нутгийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ыг баримталлаа.

в/ Орон нутгийн төсвийн урсгал зарлага

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн, төсвийн зарлагын шинэчлэлийг хэрэгжүүлж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд орон нутгийн төсвийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад зарим зардал хүрэлцэхгүй байгааг харгалзан төсвийн урсгал зарлагатай холбоотой дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд,

- Цалин, тэтгэврийг инфляцийн өсөлттэй уялдуулж нэмэгдүүлэх

Засгийн газрын 2018 оны 263, 264 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлсэн шийдвэрийн нөлөөлөл болон, 2019 онд төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх эх үүсвэрт нийт 697,2 сая төгрөгийг зарцуулна.

- Дотоод албан томилолтын тариф нэмэгдэнэ.

Зах зээл дэх бараа, ажил үйлчилгээний үнэ тарифын өөрчлөлт, ялангуяа зочид буудал, тээвэр шатахууны үнийн өсөлтийг харгалзан холбогдох судалгаанд үндэслэн тарифыг шинэчлэн тогтоохоор тооцож шаардагдах зардлыг нэмэгдүүлсэн.

- Төсвийн тэгш, шударга хуваарилалтыг хангана.

Орон нутгийн төсвийн суурь зардлыг тухайн орон нутгийн алслалт, хүн ам, малын тоо толгой, газар нутгийн хэмжээ, газарзүйн онцлог, дэд бүтцийн хөгжил, тухайн бүс нутаг дахь бараа үйлчилгээний зах зээлийн үнэ ханш зэрэг орон нутгийн онцлог, хэрэгцээнд тохирсон байдлаар тооцсон. Энэ хүрээнд орон нутгийн төсвийн байгууллагуудын дотоод албан томилолт, тээвэр шатахуун, бичиг хэрэг, шуудан холбоо зэрэг зардлын хэмжээг 2018 оны түвшнээс нэмэгдүүлсэн.

- Сумын санхүүгийн албанаас нягтлан бодогч нарыг холбогдох төсвийн байгууллагад шилжүүлнэ.

Өмчийн ашиглалт хамгаалалт, бүртгэлийг сайжруулах зорилгоор сумын санхүүгийн албанаас сургууль, цэцэрлэг, эмнэлгийн нягтлан бодогч нарыг тухайн байгууллагад нь шилжүүлэн ажиллуулах зохицуулалт хийнэ. 2019 оны төсвийн жилээс эхлэн 8000-аас доош хүн амтай сумын эмнэлэг, болон боловсролын байгууллагад 2 нягтланг шилжүүлэн ажиллуулж, харин сумын Засаг даргын тамгын газрын бүтэц орон тоонд сумын санхүүгийн албыг хэвээр үлдээн 3 орон тоотойгоор ажиллуулахаар тооцсон.

- Нийгмийн халамжийн санг нэгдсэн удирдлагаар хангаж, үйлчилгээг цаг хугацаанд нь шуурхай хүргэнэ.

Байнгын давтамжтай нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээг өрхийн мэдээллийн санг түшиглэн улсын төсвөөс шууд олгохоор тооцож орон нутгийн төсөвт тусгагдаг байсан хөрөнгийг шилжүүлж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсөвт тусгасан.

- Хот тохижилтын асуудал хариуцсан байгууллагыг аж ахуйн тооцооны зарчмаар ажиллуулна.

Орон нутгийн Хот тохижилтын асуудал хариуцсан байгууллагыг аж ахуйн тооцооны зарчмаар ажиллуулж орон тоо, техник хэрэгслийн хэрэгцээ шаардлагаа тооцож, менежментээ өөрсдөө хариуцдаг тогтолцоонд шилжүүлнэ. Нийтийн эзэмшлийн гудамж талбайг цэвэрлэх, цэцэрлэгжүүлэх зардлыг төсвөөс санхүүжүүлнэ. Мөн орон нутгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг хог хаягдал зайлуулах, устгах, цэвэрлэх арга хэмжээнд бүрэн зарцуулахаар тооцоолсон.

-Өмчийн ашиглалт, хамгаалалт, үр ашгийг сайжруулах зорилгоор сургууль, цэцэрлэг, эмнэлгийн байр ашиглалттай холбоотой зардлыг орон нутаг хариуцна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, сумын эрүүл мэндийн төв зэрэг 7 байгууллагын байр ашиглалтын зардал /гэрэл цахилгаан, халаалт, цэвэр бохир ус, байрны түрээс, урсгал засвар/-ыг орон нутаг хариуцдаг байхаар Төсвийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан ба орон нутгийн суурь зарлага 5,5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.

- Соёл урлаг, спортын чиг үүргийг орон нутаг бие даан хэрэгжүүлнэ.

Соёл, биеийн тамирын салбарын тусгай зориулалтын бүрэлдэхүүнд багтдаг орон нутгийн Музей, Хөгжимт жүжгийн театр, Соёлын төв, Соёлын ордон, Номын сан, Биеийн тамир спортын газрын үйл ажиллагааны урсгал зардал 2,0 тэрбум төгрөг тусгагдсан.

- Урьдчилан төлөвлөх боломжтой зардлыг төсвийн нөөц хөрөнгөөр санхүүжүүлэхгүй.

Баяр наадам тэмдэглэх, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах гэх мэт урьдчилан төлөвлөх боломжтой зардлыг нөөц хөрөнгөөс санхүүжүүлдэг байсныг өөрчлөн орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тооцож шаардагдах зардлын хэмжээг нэмэгдүүлсэн.

г/ Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагыг санхүүжүүлнэ.

- Төсвийн тухай хуульд заасны дагуу сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, газрын харилцаа кадастр, хүүхдийн хөгжил хамгааллын үйлчилгээг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлж, нийт 30,2 тэрбум төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудыг санхүүжихээр тооцооллоо.

- Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг хүүхдийн тоо, гэмт хэргийн гаралт зэрэг статистик үзүүлэлт болон хүүхэд хамгааллын үйлчилгээний хэрэгцээний судалгааг харгалзсаны үндсэн дээр орон нутгийн хүүхдийн байгууллагын төсөвт хүүхэд хамгааллын чиглэлээрх арга хэмжээг санхүүжүүлэхээр 62,0 сая төгрөг хуваарилсан байна.

4.2 Аймгийн нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт

Төсвийн зарчмуудыг баримтлан, дээр дурдсан голлох өөрчлөлтүүдийг оруулан тооцоход аймгийн 2019 оны нийт төсвийн орлого, зарлагыг 59,7 тэрбум төгрөг болж, төсвийн тэнцлийг хангаж байна.

ТАВ. АЙМГИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН**5.1. Төсвийн орлогын төлөвлөлт**

Төсвийн орлогын 2019 оны төсвийн төслийг боловсруулахдаа төсвийн орлогын боломжит эх үүсвэрүүдийг бүрэн дайчилж, өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрх зүйн орчны хүрээнд Сангийн яамнаас ирүүлсэн чиглэл, 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, сүүлийн 6 жилийн судалгаа зэрэгт үндэслэн 2018 оны төсвөөс 2,4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 23,1 тэрбум төгрөг байхаар тооцлоо.

5.1.1 Хувь хүний орлогын албан татвар

- Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, үнийн өсөлтийн түвшин зэрэгтэй уялдуулан цалин, хөдөлмөрийн хөлсний хэмжээнээс хамааран нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. 2019 оноос албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ 0-6,0 сая төгрөгд хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт 240.0 мянга, 6.0-12.0 сая төгрөгд 220,0 мянга, 12.0-18.0 сая төгрөгд 200.0 мянга, 18.0-24.0 сая төгрөгд 180.0 мянга, 24.0-30.0 сая төгрөгд 160.0 мянга, 30.0-36.0 сая төгрөгд 140.0 мянган төгрөг, 36.0 сая төгрөгөөс дээш бол хөнгөлөлт тооцохгүй байхаар батлагдсан байна.
- Цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогын албан татвараар 2017 онд 4,1 тэрбум төгрөг төвлөрсөн ба 80,0 хувийг төр төсвийн байгууллагуудад ажиллагсдын цалин хөлсний орлого болон түүнтэй адилтгах орлогын албан татвараас бүрдэж байгаа бөгөөд 2019 онд цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогыг 4,3 тэрбум төгрөгөөр тооцлоо.
- Хуулийн этгээд байгуулахгүйгээр бие даан мэргэжлийн үйлчилгээ, үйлдвэрлэл, арилжаа эрхэлж олсон орлогод ногдох орлогыг нэмж тооцон үйл ажиллагааны орлогыг нийт 83,0 сая төгрөгөөр тооцлоо.
- ХААН банк, Төрийн банк, Хас банк, Капитал банкинд хадгаламж эзэмшигч иргэдийн судалгаанд үндэслэн хадгаламжийн хүүний орлогод татвар ногдуулж хөрөнгийн орлогыг бүрдүүлэхээр 478,8 сая төгрөг төлөвлөж, сумдад хуваариллаа.
- Монгол Улсын Их Хурлын 2015 оны 40-р тогтоолын дагуу хоршооны гишүүн малчин, мал бүхий иргэдэд олгох хонины ноосны килограмм тутамд олгох урамшууллыг 1000 төгрөгөөр, тэмээний ноосыг 2000 төгрөгөөр тооцон, ноосны урамшууллын орлогоос татвар авахаар тооцон 191,3 сая төгрөг, шууд бус орлогыг сүүлийн 5 жилийн дунджаар 568,8 сая төгрөгөөр тооцлоо.
- Хувь хүний орлогын албан татварын буцаан олголтоор 2018 онд 1202 иргэнд 553,2 сая төгрөгийг олгосон бөгөөд жилд дунджаар 20,0-50,0 сая төгрөгөөр нэмэгдэж байна. Иймээс 2019 онд 600,0 сая төгрөг олгохоор тооцлоо.

Хүснэгт №11. 2014-2018 оны хувь хүний орлогын албан татварын
буцаан олголтын судалгаа /сая.төг/

№	Үзүүлэлт	2015 гүйц	2016 гүйц	2017 гүйц	2018 гүйц	2019 төл
---	----------	-----------	-----------	-----------	-----------	----------

1	Хүний тоо	1228	1191	1158	1202	1213
2	Олгосон дүн /сая.төг/	422,8	470,6	495,2	553,2	600,0

5.1.2 Хөрөнгийн албан татвар

Хөрөнгийн албан татварын орлогод үл хөдлөх хөрөнгийн албан татвар, бууны албан татвар, авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогыг хамааруулж, нийт 773,8 сая төгрөгөөр төлөвлөв. Бүтцийн хувьд авч үзвэл үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого 424,4 сая буюу 54,8 хувь, бууны албан татварын орлого 69,4 сая буюу 9,0 хувь, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлого 280,0 сая буюу 36,2 хувийг эзэлж байна.

Дээрх орлогыг өмнөх жилүүдийн гүйцэтгэл болон энэ оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлд үндэслэн тооцсон болно.

5.1.3 Бусад татвар, төлбөр хураамж

Төрийн эрх бүхий байгууллагаас Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан үйлчилгээ үзүүлсний төлөө иргэн, хуулийн этгээдийн төлж байгаа тэмдэгтийн хураамжийн сүүлийн 5 жилийн гүйцэтгэлд үндэслэн 195,0 сая төгрөгөөр тусгалаа.

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн хураамжийн орлого, хог хаягдлын үйлчилгээний хураамж, ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамжийн орлогыг 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэл үндэслэн төлөвлөсөн.

2018 оны хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг сумын ИТХурлаар тогтоосон үнэлгээг харгалзан, сумын төвийн өрхийн 90,0 %-иар тооцон 136,6 сая төгрөгөөр төлөвлөв. Цаашид сумын Засаг дарга түүний тамгын газрын холбогдох албан тушалтанууд “Хог хаягдлын тухай” хуулийн дагуу хогны менежментийг боловсронгуй болгон айл өрх, албан байгууллагуудаас авах хог хаягдлын хураамжийн орлогыг нийгэм эдийн засгийн нөхцөл байдалд нийцүүлэн тухайн сумын ИТХ-аар батлуулан тогтоож мөрдөх шаардлагатай байна.

АИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаар батлагдсан “Газрын төлбөрийн бааз” болон “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-д тусгасны дагуу газрын төлбөрийн орлогыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газартай хамтран тооцож 245,0 сая төгрөгийг тус тус орлогын төлөвлөгөөнд тусгалаа. Энэ нь 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэлтэй харьцуулахад 55,5 сая төгрөг буюу 22,7 хувиар өссөн ба 2018 оны төлөвлөсөн орлогоос буурч байна. 2013 оноос суманд газрын төлбөрийн орлого төвлөрөхөө больсноос сумдад газрын төлбөрийн орлогыг төсөвт оруулах хяналт суларсан, газрын дуудлага худалдаанд ач холбогдол өгөх нь багасч, аль болох төсөл сонгон шалгаруулалтаар үнэгүй газрыг олгох хандлагатай болсон. Өмнөх жилүүдийнхтэй харьцуулахад ашигтай байршил сайтай газруудад дуудлага худалдаа явагдах нь буурсан ба Аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2018 оны 03 сарын 36 дугаар тогтоолоор газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хугацаа дуусаж, сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө хийх хүртэлх хугацаанд сумын ИТХуралд иргэний ахуйн хэрэгцээ, газар тариалан, өвөлжөө, хаваржааны газраас бусад газрыг олгохгүй байхаар тусгагдсан.

2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр ойгоос мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хураамжийн орлого тасарч байгаа нь төлөвлөсөн хэмжээнд мод бэлтгэлийн ажил явагдахгүй байгааг харуулж байна. Иймд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайдын тушаалын дагуу 300,8 сая төгрөгийн орлого оруулахаар тооцож өмнөх оны түвшнээс буурууллаа.

Мөн ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 36,4 сая төгрөгөөр төлөвлөлөө.

Ус ашигласны төлбөрийн орлогыг 15,5 тэрбум төгрөгөөр төлөвлөж байна.

Хүснэгт №12. Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн ашигладаг усны төлбөрийн орлогын судалгаа /мян.төг/

Үзүүлэлт	2015 гүйц	2016 гүйц	2017 гүйц	2018 ХБГ	2019 санал
Усны хэмжээ /м3/	11,237,782.30	11,485,658.50	15,481,798.00	17,474,182.00	17,645,206.79
Төлбөрийн дүн /мян.төг/	10,120,364.04	11,175,152.43	13,550,000.00	14,328,975.21	14,500,000.00

2018 онд хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр ус ашигласны төлбөрийн орлогоор 14692.2 сая төгрөг орохоор төлөвлөсний 14329.0 сая төгрөг буюу 97,5 хувийг Эрдэнэт үйлдвэр ХХК-аас орох орлого эзэлж байна. Ус ашигласны төлбөрийн орлого 2018 оны батлагдсан төсөвтэй харьцуулахад 17,4 хувиар өслөө.

Ус ашигласны төлбөрийн орлогыг 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийг үндэслэн Сангийн яамны хянасан дүнгээс 965,4 сая төгрөгөөр нэмэгдүүллээ. Энэ нь уул уурхай олборлолт явуулдаг ААН-үүдээс урд жилүүдийн төлөвлөсөн орлогын дутууг төвлөрүүлэх, тухайн жилийн төлөвлөсөн орлогыг бүрэн хурааж төсөвт төвлөрүүлэх үүргийн дагуу нэмж тооцож төлөвлөсөн болно.

5.1.4 Татварын бус орлого

2019 оны аймаг, сумын төсөвт татварын бус орлогоор 571,1 сая төгрөг төлөвлөснөөс хувьцааны ногдол ашгийн орлогоор 25,0 сая, хүү, торгуулийн орлогоор 467,6 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 283,4 сая, түрээсийн орлогоор 26,9 сая, бусад орлогоор 51,6 сая, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогоор 20,0 сая төгрөг оруулахаар төлөвлөлөө. Дээрх орлогуудыг 2017 оны гүйцэтгэл, 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэн тооцсон болно.

5.2 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгийн орлого

2019 онд сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, газрын харилцаа, кадастр, хүүхдийн хөгжил, хамгааллын чиг үүргийг Засгийн газартай гэрээ байгуулан төлөөлөн хэрэгжүүлэх ба нийт 30,2 сая төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжихээр тооцлоо.


Орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгийн орлогоор аймагт 3,6 тэрбум төгрөг хуваарилагдаж ирснийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Орон нутгийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ыг баримталлаа.

ЗУРГАА. ТӨСВИЙН ЗАРЛАГА

2019 оны орон нутгийн төсвийн зардлын төслийг боловсруулахдаа Монгол улсын их хурал, Засгийн газраас баримталж буй бодлого, хууль тогтоомж, статистик тоо мэдээ, үнэ ханш зэрэг өөрчлөлтүүд, урсгал төсвийн зарлагын шинэчлэлийг тусгасан.

Төсвийн тухай хуулийн дагуу орон нутгийн төсвийн суурь зардалд аймаг, сумын удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зардал, нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, нийгмийн халамж асрамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах арга хэмжээг оруулж 59,7 тэрбум төгрөгөөр тооцлоо.

Зураг №2: 2019 оны төсвийн зарлагын бүрэлдэхүүн /сая.төг/



Нийт зарлагын 43.4 хувийг орон нутгийн төсвийн урсгал орлогоор, 50.6 хувийг тусгай зориулалтын шилжүүлэг, 6.0 хувийг орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгийн орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөлөө.

Бүтцийн хувьд авч үзвэл цалин нийгмийн даатгалын шимтгэлд 55,8 хувь, бараа үйлчилгээний бусад зардалд 34,0 хувь, татаас урсгал шилжүүлэгт 1,8 хувь, орон нутгийн хөрөнгө оруулалтад 8,4 хувийг зарцуулахаар байна.

Зураг №3. Төсвийн зарлагын бүтэц /хувиар/



6.1. Орон нутгийн суурь зардал

Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой зардалд аймаг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Багийн засаг дарга түүнчлэн Засаг даргын шууд харъяанд байгаа орон нутгийн төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны урсгал болон хөрөнгийн зардлыг оруулж, “Орон нутгийн төсвийн аргачлал батлах тухай” Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын дагуу тооцож төлөвлөсөн.

Сумдын үндсэн тэнцлийн алдагдлыг нөхөх зорилгоор аймгийн төсвөөс 2019 онд олгох санхүүгийн дэмжлэгийн тооцооллыг Төсвийн тухай хууль болон Орон нутгийн суурь зарлага тооцох аргачлалд үндэслэн 4,6 тэрбум төгрөгөөр тооцсон нь 2018 оноос 0,6 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

2019 оны урсгал зардал тусгагдсан зардлын талаар товч дурьдвал:

- Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн орон нутгийн өөрөө удирдах болон засаг захиргааны байгууллагын хэрэгжүүлэх чиг үүргийг харгалзан аймгийн ИТХ-ын төсвийг 406,0 сая, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах зөвлөлийн зардлыг Шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 2017 оны гүйцэтгэлд үндэслэн 86,0 сая төгрөгөөр тооцлоо.
- Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газрын үйл ажиллагааны төсвийг 1780,4 сая төгрөгөөр тооцож тусгалаа.
- Сумдын ИТХ, ЗДТГ, багийн Засаг дарга зэрэг байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулахад шаардагдах тээвэр шатахуун, бичиг хэрэг, урсгал засвар, дотоод албан томилолтын зардлыг шинэчлэгдсэн тариф болон төсвийн зарлагын шинэчлэлийн хүрээнд сумдын саналыг харгалзан сумын ИТХ, ЗДТГ, Баг, Ойн ангийн төсвийн суурь зардлыг нийт 7259,9 сая төгрөгөөр тооцов.
- 2019 онд орон нутгийн төсвийн байгууллагаас тэтгэвэрт гарах 22 төрийн албан хаагчид олгох буцалтгүй тэтгэмжид 215,9 сая төгрөг тусгалаа.
- Аймаг, сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс шагнал, урамшуулал, буцалтгүй тусламж, уналга, цугларалт, бэлтгэл сургуулилт, мал тооллогын зардал, байгалийн гамшиг, ослын үр дагаврыг арилгах, гоц халдварт өвчний голомтыг арилгах, тархалтыг хязгаарлах болон Засаг даргын хуулиар олгогдсон бүрэн

эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээг санхүүжүүлдэг. Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг 2017 оны батлагдсан түвшинд буюу 444,1 сая төгрөгөөр тусгалаа. Аймгийн Ахмадын холбооны төсвийг СЯ-аас өгсөн суурь зардлын түвшинд буюу 44,1 сая төгрөгөөр тооцож, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнд төрийн өмнөөс гүйцэтгэх ажил үйлчилгээ гэсэн эдийн засгийн ангилалд төлөвлөлөө.

- Сумын Засаг дарга нарын нөөц хөрөнгийн зардал $5,0 / 17 * 5,0 = 85,0$ сая/ сая төгрөгөөр тооцогдон аймгийн суурь зардалд тусгагдан Сангийн яамнаас хянагдан ирдэг ба аймгийн төсвийн нөөц бололцоо, сумын дарга нарын хэрэгжүүлэх чиг үүрэг зэргийг тооцон, сум тус бүрийн суурийг $5,0 / 17 * 5,0 = 85,0$ сая/ сая төгрөгөөр нэмэгдүүлж, тус бүр 10,0 сая төгрөгөөр тооцлоо.
- Баяр наадам тэмдэглэх болон урьдчилан төлөвлөх боломжтой зарим зардлыг нөөц хөрөнгөөс санхүүжүүлдэг байсныг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тооцож аймаг, сумын баяр наадам тэмдэглэх зардлыг Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолоор заасан үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээнд үндэслэн тооцож аймаг, сумын Засаг даргын тамгын газарт тусад нь арга хэмжээнд тусгасан.
- Аймгийн Засаг даргын Хөгжлийн хөтөч хөтөлбөрт туссан 7 дэд хөтөлбөр, бусад дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг өсгөж 350,0 сая, аймгийн төсвөөс 2019 онд хэрэгжих барилга байгууламж, зам гүүр, барилгын их засвар, гэрэлтүүлэг, худаг гаргах зэрэг ажлын гүйцэтгэлд мэргэжлийн хяналтыг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар гүйцэтгэхээр, хөндлөнгийн хяналтыг аймгийн ИТХ, аймгийн ЗДТГ, иргэдийн төлөөлөлтэй хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж, техник хяналтын зардлыг 25,0 сая төгрөгөөр тооцож, аймгийн Засаг даргын ангилагдаагүй бусад арга хэмжээний зардалд нийт 375,0 сая төгрөг төлөвлөлөө.
- Сумын Ахмадын хорооны үйл ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх зорилгоор сум бүрт 1,5 сая төгрөг нийт 25,5 сая төгрөгийг сумын Засаг даргын Тамгын газрын суурь зардалд ахмадын хорооны үйл ажиллагааны зардал гэж тусгасан.
- Байгаль орчин аялал жуулчлалын газар, Санхүүгийн хяналт аудитын алба, Орон нутгийн Өмчийн газар, Хүүхдийн сувиллын ясли зэрэг байгууллагуудын зардлыг Сангийн яамнаас хянаж баталсан 2019 оны суурь зардлын түвшинд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулахгүй байх хэмжээнд тооцож төлөвлөсөн.
- Мал эмнэлгийн үйлчилгээний хөлсөнд 429,9 сая төгрөг төлөвлөж, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжихээр тооцлоо.
- “Авто тээврийн тухай”, “Ахмадын тухай”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” зэрэг хуулийн дагуу Булган хот доторхи зорчигч тээврийн нөхөн олговрыг тооцож 12,0 сая төгрөг тусгалаа.
- Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогыг аймгийн Авто замын санд төвлөрүүлэх ба авто зам ашигласны төлбөр 60,0 сая төгрөгийн орлогыг нэмж тооцон нийт 312,0 сая төгрөгөөр төлөвлөлөө.

- Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1.4 дэх заалтыг үндэслэн авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын суурь орлогын 10 хувь буюу 28,0 сая төгрөгийг жолоочийн даатгалын санд төвлөрүүлэхээр тооцлоо.
- Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг бусад зүйл зардалд шилжүүлэн зарцуулахгүй бөгөөд хэрэгжүүлэх арга хэмжээг аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх “Хөгжлийн хөтөч” үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Ногоон хөгжлийн хөтөлбөр, Монгол улсын Засгийн газрын 2014 оны 43 тоот тогтоол зэрэгтэй уялдуулан 5,4 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь 2018 оноос 17,3 хувь буюу 0,8 тэрбум төгрөгөөр өссөн байна.
- Аймгийн Гамшгаас хамгаалах санд аймгийн төсвөөс 100,0 сая, аймгийн Цэргийн дүйцүүлэх албаны зардлыг 80,0 сая төгрөгөөр тооцон төсвийн иж бүрэн байдлыг ханган тусгав.
- Нийгмийн халамжийн санг нэгдсэн удирдлагаар хангаж, үйлчилгээг шуурхай хүргэх, халамжийн сангийн хөрөнгийг бусад зориулалт, арга хэмжээнд шилжүүлэн санхүүжүүлэх, төсвийн сахилга батыг алдагдуулах эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс орон нутгийн суурь зарлагад тооцогддог халамжийн зардлыг улсын төсөвт татаж, хоёр төрлийн үйлчилгээг орон нутагт үлдээсэн. Олон нийтийн оролцоо түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардалд 24,0 сая, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжид 55,2 сая төгрөг тусгагдсаныг зориулалтын дагуу санхүүжүүлнэ.
- Нягтлан бодогчид сумын ЗДТГ-т төвлөрөн ажилласнаар сумын сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг байгууллагуудад нягтлангийн хараа хяналт алдагдах асуудлууд гарч байна. Нөгөөтэйгөөр, сумын санхүүгийн алба нь жилийн турш нийт 26 төрлийн тайлан, мэдээг 1-12 удаагийн давтамжтайгаар, 8-9 өөр програм хангамж ашиглан боловсруулж, мэдээлдэг. Эдгээр тайлан, мэдээний тайлант хугацаа хоорондоо давхцдаг, олон төрлийн програм хангамж дээр ажиллах шаардлагатай байдаг зэрэг нь тэдний ажлын ачааллыг нэмэгдүүлэхэд голлон нөлөөлж байна. Сумын санхүүгийн албанаас сургууль, цэцэрлэг, эмнэлгийн нягтлан бодогч нарыг тухайн байгууллагад нь шилжүүлэн ажиллуулах зохицуулалт хийж, сумын тамгын газарт санхүүгийн албыг 3 орон тоотойгоор ажиллуулахаар тооцож, орон нутаг хариуцсан нягтлан бодогчийн орон тоо, цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 153,9 сая төгрөгийг тусгасан. Үүнтэй холбогдуулан сумын санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг нормативыг Засгийн газрын тогтоолоор шинэчлэн батална. Иймд сумын санхүүгийн албаны ажлын ачаалал, уялдаа холбоог дахин нягталж орон тоо, чиг үүргийн давхардал, хийдэл үүсгэхгүй байхаар ажлын ачааллыг нягтруулан жигд хуваарилан зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.
- Орон нутгийн Хот тохижилтын асуудал хариуцсан байгууллагыг аж ахуйн тооцооны зарчмаар ажиллуулж орон тоо, техник хэрэгслийн хэрэгцээ шаардлагаа тооцож, менежментээ өөрсдөө хариуцдаг тогтолцоонд шилжүүлэхээр тооцож үйл ажиллагааны зардлыг 440,7 сая төгрөгөөр тусгалаа. Иймээс хог хаягдлын үйлчилгээний хураамжийн тарифыг бодитой тогтоож ИТХ-аар батлуулах, хот тохижилтын үйлчилгээг тарифтай болгож гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх зэрэг арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна. Хот

тохижилт үйлчилгээний санхүүжилтийг үр ашигтай, оновчтой зарцуулах зорилгоор шаардагдах зардлыг дараах зориулалт, арга хэмжээгээр төлөвлөж зарцуулахыг анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлэг
 - Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн цэвэрлэгээ үйлчилгээ
 - Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэгээ үйлчилгээ
 - Хотын доторх ногоон байгууламжийн үйлчилгээ
 - Хотын доторх золбин муур, нохой устгал
- Хүүхэд хөгжил, хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилт 62,0 сая төгрөгийг Орон нутгийн хүүхэд, хөгжил хамгааллын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын төсөвт хуваарилсан нь хүүхэд хамгааллын чиглэлээр салбар дундын хамтын ажиллагааг дэмжих, гэр бүлийн орчин, эрүүл мэнд, боловсрол, хэвлэл мэдээлэл, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийн оролцоог хангах, эрсдлээс урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлж байна.
- Орон нутгийн сургууль, цэцэрлэг сумын эрүүл мэндийн төв, зэрэг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын байр ашиглалтын зардал /гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир ус, байрны түрээс, урсгал засвар/-ыг орон нутаг хариуцдаг байхаар хуулийн зохицуулалт хийгдэж орон нутгийн суурь зарлагад 5,5 тэрбум төгрөг тусгагдсаныг 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, байгууллагуудаас ирсэн төсвийн төсөл зэрэгт үндэслэн хуваариллаа.
- Орон нутаг дахь соёл урлаг, спортын чиг үүргийг бие даан хэрэгжүүлэх болсноор эдгээр байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардалд 2,2 тэрбум төгрөгийг хуваарилсан бөгөөд цашид эдгээр байгууллагуудыг орон нутгийн онцлогтоо нийцүүлж үр ашигтай, хэмнэлттэй ажиллах чиглэлээр бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийх арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Соёл урлагийн байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөөг тавиагүй баталсан ч тодорхой үүрэг хариуцлагатай байх, соёлын салбарт үүсэх тогтмол зардлын өр төлбөрийг барагдуулах бодлогын түвшинд тооцоолол хийж аймаг, сумын соёлын байгууллагуудад 59,0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөг тусгалаа. Давж биелүүлсэн орлогын хэмжээгээр ажилтнуудын нийгмийн баталгааг хангах, цалин урамшуулал, уран бүтээл туурвих зэрэг бусад шаардлагатай зардалд бие даан зарцуулах эрх нээлттэй байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлд нийцүүлэн Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам” батлагдан гарсан. Энэхүү журмаар бүх шатны төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах, төсвийн зардлыг хэмнэх, байгууллагын орлогоо давуулан биелүүлэх идэвх, санаачилгыг бий болгож, бий болсон нэмэлт эх үүсвэрийг дараах зориулалтаар уян хатан захиран зарцуулах эрх олгогдож байна. Тухайлбал, хамт олон, ажилтныг ажлын үр дүнгээр нь урамшуулах, тэдний нийгмийн баталгааг сайжруулах, тухайн байгууллагын хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт хийх, төсвийн хүндрэлтэй үед үндсэн үйл ажиллагаанд дутагдаж байгаа бусад зардалд шилжүүлэн зарцуулах боломж бүрдэж байна.

6.2 Орон нутгийн хөрөнгө оруулалт

Орон нутгийн чиг үүрэгт хамааралтай тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх “Хөгжлийн хөтөч” үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхээр орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих зардалд 1,1 тэрбум, орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжих хөрөнгө оруулалтад 1,6 тэрбум, аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих зардалд 0,3 тэрбум, байгаль хамгаалах сангаас хэрэгжих хөрөнгө оруулалт хөтөлбөр төсөл арга хэмжээнд 5,4 тэрбум нийт 8,4 тэрбум төгрөг төлөвлөлөө.

Хөрөнгө оруулалтыг эх үүсвэр бүрээр нь танилцуулж байна.Үүнд:

6.2.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

2019 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 23 төсөл арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхээр 1,1 тэрбум төгрөг тусгалаа. Орон нутгийн суурь зарлагад хөрөнгө оруулалтын зардал тусгагдаагүй бөгөөд аймгийн 2018 оны үндсэн тэнцлийн ашгаас санхүүжүүлэхээр тооцогдсон.

Хүснэгт №14. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний жагсаалт /мян.төг/

№	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал байршил	Хэрэгжүүлэх хугацаа	Төсөвт өртөг	2019 онд санхүүжих
1	Сумдын ЗДТГ-ын суудлын автомашиныг шинэчлэх /Дашинчилэн, Бүрэгхангай, Хангал, Орхон сум/	2019 он	200,000.0	200,000.0
2	Хөдөөгийн багийн Засаг дарга нарыг мотоциклээр хангах /69 ширхэг/	2019 он	103,500.0	103,500.0
3	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга барих, 75 хүүхэд /Сэлэнгэ сум/	2019-2020 он	835,361.4	150,000.0
4	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга барих, 75 хүүхэд /Гурванбулаг сум/	2019-2021 он	947,431.9	150,000.0
5	Аймгийн ахмадын өргөө барих	2019-2021 он	1,200,000.0	300,000.0
6	Баян-Агт сумын Засаг даргын Тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	2019 он	10,000.0	10,000.0
7	Баяннуур сумын Засаг даргын Тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	2019 он	10,000.0	10,000.0
8	Бугат сумын Засаг даргын Тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	2019 он	10,000.0	10,000.0
9	Булган сумын Засаг даргын Тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	2019 он	10,000.0	10,000.0
10	Бүрэгхангай сумын Засаг даргын Тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	2019 он	10,000.0	10,000.0
11	Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	2019 он	10,000.0	10,000.0
12	Дашинчилэн сумын Засаг даргын Тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	2019 он	10,000.0	10,000.0
13	Могод сумын Засаг даргын Тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	2019 он	10,000.0	10,000.0
14	Орхон сумын Засаг даргын Тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	2019 он	10,000.0	10,000.0

15	Рашаант сумын Засаг даргын Тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	2019 он	10,000.0	10,000.0
16	Сайхан сумын Засаг даргын Тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	2019 он	10,000.0	10,000.0
17	Сэлэнгэ сумын Засаг даргын Тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	2019 он	10,000.0	10,000.0
18	Тэшиг сумын Засаг даргын Тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	2019 он	10,000.0	10,000.0
19	Хангал сумын Засаг даргын Тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	2019 он	10,000.0	10,000.0
20	Хишиг-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	2019 он	10,000.0	10,000.0
21	Хутаг-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	2019 он	10,000.0	10,000.0
22	Хялганат тосгоны Захирагчийн ажлын албаны компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	2019 он	10,000.0	10,000.0
Нийт дүн			3,456,293.3	1,073,500.0

6.2.2. Орон нутгийн хөгжлийн сан

Орон нутгийн хөгжлийн санд хуваарилагдан ирсэн 3,6 тэрбум төгрөгийг Засгийн 2018 оны 228 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Орон нутгийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ыг үндэслэн 1,4 тэрбум төгрөгийг сумын орон нутгийн хөгжлийн санд, 1,6 тэрбум төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн санд хуваариллаа.

Дээрх аргачлын дагуу сумдын орон нутгийн хөгжлийн санд итгэлцүүрт үндэслэн 718,6 сая, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 10 суманд 222,7 сая төгрөг, Тогтвортой амьжиргаа-3 төслийн дэмжлэг 343,3 сая, төслийн урамшуулал авах нөхцөл хангасан нэр бүхий 6 суманд 84,5 сая төгрөг хуваарилснаар нэг суманд дунджаар 49,7-128,3 сая төгрөг ногдож байна.

№	СУМ	Итгэлцүүрт үндэслэсэн хуваарилалтын дүн	ТА-3 төслийн дэмжлэг	ТА-3 төслийн урамшуулал	АМХБАТЗ-ийн төлбөрийн 50%	Сумдад хувиарлагдах
1	Баян-Агт	44,924.8	21,463.4	13,889.0		80,277.2
2	Баяннуур	24,287.8	11,603.8		13,825.6	49,717.2
3	Бугат	27,902.2	13,330.7		47,082.0	88,314.9
4	Булган	58,906.4	28,143.2	18,508.0		105,557.6
5	Бүрэгхангай	36,739.8	17,552.9		68,765.1	123,057.8
6	Гурванбулаг	42,099.5	20,113.5	13,240.3	1,868.8	77,322.1
7	Дашинчилэн	39,791.4	19,010.8	12,047.3	16,320.9	87,170.4
8	Могод	36,382.8	17,382.3			53,765.1
9	Орхон	38,058.4	18,182.9			56,241.3
10	Рашаант	43,330.7	20,701.7	13,656.4	4,166.7	81,855.5
11	Сайхан	41,804.3	19,972.5	13,187.8	6,446.2	81,410.8
12	Сэлэнгэ	52,113.7	24,898.0		38,949.4	115,961.1
13	Тэшиг	80,465.8	38,443.6		9,415.1	128,324.5
14	Хангал	47,143.4	22,527.3			69,670.7

15	Хишиг-Өндөр	32,806.6	15,673.8		15,844.5	64,324.9
16	Хутаг-Өндөр	71,809.9	34,308.1			106,118.0
	НИЙТ ДҮН	718,567.4	343,308.5	84,528.8	222,684.3	1,369,089.0

Аймгийн 2019 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулахдаа аймгийн засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх “Хөгжлийн хөтөч” Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, харьяа хэлтэс албад, агентлагуудаас ирсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналыг эрэмбэлж аймгийн 16 сум 1 тосгоны иргэдээс санал авах ажлыг зохион байгуулж, эрэмбэлэн боловсрууллаа.

Хүснэгт №15. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлэх

төсөл арга хэмжээний жагсаалт

/мян.төг/

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил		Хэрэгжүүлэх хугацаа	Төсөвт өртөг	2019 онд санхүүжих дүн
1. Шилжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээ		I		98,000.0	49,000.0
1.1	Техник технологи, инноваци нутагшуулах, үйлдвэрлэлийн бүсийн үйл ажиллагааны ТЭЗҮ боловсруулах	2	2018-2019	98,000.0	49,000.0
2. Шинээр эхлэх хөрөнгө оруулалт		II		3,435,209.4	1,726,224.2
2.1	Булган аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө хийлгэх	3	2019-2020	743,400.0	280,000.0
2.2	Дулааны станцын цахилгаан хангамжийг сайжруулан, нэг хэлхээ газрын кабелиар аваарын нөөц цахилгаан эх үүсвэртэй болгох	4	2019	307,768.0	307,768.0
2.3	Эмнэлгийн шинэ, хуучин барилгыг хүүжүүвчээр холбох /Хишиг-Өндөр сум/	5	2019	41,000.0	41,000.0
2.4	Спорт заалны барилга шинээр барих /Орхон сум/	6	2019-2020	455,000.0	200,000.0
2.5	Багийн хөгжлийн төв барих /Рашаант/	7	2019	15,000.0	15,000.0
2.6	Аймгийн Нөөцийн газарт өвс тэжээлийн саравч барих, нөөц бүрдүүлэх	8	2019	50,000.0	50,000.0
2.7	Эрүүл мэндийн төвд лабораторын тоног төхөөрөмж /Гурванбулаг сум/	9	2019	24,098.0	24,098.0
2.8	Сургуулийн спорт заалны дээврийн засвар /Баяннуур сум/	11	2019	28,300.0	28,300.0
2.9	Эрүүл мэндийн төвийн засвар хийх /Баян-Агт сум/	12	2019-2020	241,500.0	154,400.0
2.10	Эрүүл мэндийн төвийн засвар хийх /Хялганат тосгон/	13	2019	188,000.0	188,000.0
2.11	Булган аймгийн Нэгдсэн эмнэлэгийн 50 ортой төрөх эмнэлгийн барилгын дээврийн засвар	14	2019	106,157.4	106,157.4
2.12	120 хүүхдийн хүчин чадалтай хүүхдийн цэцэрлэгийн барилга /Тэшиг, Жаргалант баг/	15	2019-2020	1,077,416.0	220,000.0
2.13	2018 онд хэрэгжсэн барилга байгууламжийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах ажлын дутуу санхүүжилт, 2019 онд хэрэгжүүлэх барилга байгууламж ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах ажил	17	2019	117,570.0	71,500.8
2.14	Аймгийн баяр наадмыг тэмдэглэх	18	2019	40,000.0	40,000.0
3. ОНХС-аас санхүүжих суурь зардал		III		524,324.7	524,324.7
	Үүнээс:	20			
3.1	Мал эмнэлгийн үйлчилгээний зардал	21	2019	429,870.0	429,870.0
3.2	Хот тохижилт үйлчилгээний ангийн санхүүжилт	22	2019	94,454.7	94,454.7

4. Сумын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг		IV		1,369,089.0	1,369,089.0
4.1	Сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн дүн	23	2019	1,369,089.0	1,369,089.0
5. НИЙТ				5,426,623.1	3,668,637.9

Орон нутгийн хөгжлийн сангаас орон нутгийн суурь зарлага болох мал эмнэлгийн үйлчилгээний зардал 429,9 сая, тохижилт үйлчилгээний зардалд 94,4 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн.

6.2.3. Аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалт

2019 оны орон нутгийн төсвийн суурь орлогод АТӨЯХАТ-ийн орлогоор 280,0 сая төгрөг оруулахаар тооцсон бөгөөд “Жолоочийн даатгалын тухай” хуульд зааснаар 28,0 сая төгрөгийг жолоочийн хариуцлагын даатгалын санд төвлөрүүлж авто зам ашигласны төлбөрийн орлого 60,0 сая төгрөг, нийт 312,0 сая төгрөгийг дараах арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөв.

Хүснэгт №16. 2019 оны Авто замын сангаас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт /мян.төг/

Д/д	Төсөл арга хэмжээний нэр, байршил, хүчин чадал	Хэрэгжүүлэх хугацаа	Төсөвт өртөг	2019 онд санхүүжих
1	Орон нутгийн чанартай авто замын засвар, арчлалт	2019 он	175,000.0	175,000.0
2	Байгалийн гамшгийн үеийн авто зам, замын байгууламжийн засвар	2019 он	50,000.0	50,000.0
3	Булган сумын авто замын засвар	2019 он	42,000.0	42,000.0
4	Зам, тээврийн хяналтын төвийн зардал	2019 он	15,000.0	15,000.0
5	Шинээр хийлгэх зураг төсвийн зардал	2019 он	30,000.0	30,000.0
Нийт дүн			312,000.0	312,000.0

6.2.4. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний жагсаалт

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор 2019 оны байгаль хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг 5,4 тэрбум төгрөгөөр тооцсон нь 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэлтэй харьцуулбал 0,8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

2018 онд ойг нөхөн сэргээх хамгаалах, цөлжилтийг бууруулах, усны нөөцийг хамгаалах замаар усан хангамжийг сайжруулах, газар, газрын хэвлийг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах, хог хаягдлыг багасгах, биологийн төрөл зүйлийг хамгаалах, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгаль орчны тухай хуулиудыг сурталчилж мэдээлэх, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт №17. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт /мян.төг/

Д/д	Төсөл арга хэмжээний нэр байршил, хүчин чадал	Хэрэгжүүлэх хугацаа	Төсөвт өртөг	2019 онд санхүүжих
Нэг. Ой, цөлжилтийн талаар:				
1	Ойжуулалтын ажил /Сэлэнгэ, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Бүрэгхангай/	2017-2019 он	65,500.00	65,500.00

2	Ойжуулалт /300 га, Бугат, Сэлэнгэ, Могод, Хангал/	2019 он	208,500.00	208,500.00
3	Зоон давааны ойжуулалтын хашаа барих	2019 он	30,000.00	30,000.00
4	Байгалийн аясаар сэргэн ургалтыг дэмжих ажил /100 га, Бугат, Хишиг-Өндөр, Хангал/	2019 он	20,000.00	20,000.00
5	Цөлжилтийн эсрэг тал хээрийн бүсийг навчит модоор ойжуулах /10га, Орхон/	2019 он	9,050.00	9,050.00
6	Ойн хортны тэмцлийн ажил хийх /Орхон, Хутаг-Өндөр, Баян-агт, Хангал, Бүрэгхангай, Сэлэнгэ, Сайхан, Бугат, 32000га/	2019 он	471,519.88	471,519.88
7	Ой бүхий сумдад ойн хортны судалгааны ажил /50000га/	2019 он	50,000.00	50,000.00
8	Ойн ангид арчилгааны огтлолт хийх зориулалтын моторт хөрөө SHTIL/Герман MS 180 маркын 9 ширхэг/	2019 он	7,000.00	7,000.00
9	Ойн нөхөрлөлүүдийн ойн санд ой зохион байгуулалт хийлгэх /20 ойн нөхөрлөл/	2019 он	28,000.00	28,000.00
10	Элсний нүүдлийг хамгаалах /Хутаг-Өндөр, Сэлэнгэ/	2019 он	10,600.00	10,600.00
11	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчилгаа хийх /Аймгийн хэмжээнд/	2019 он	50,000.00	50,000.00
12	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, тусгай хамгаалалттай газар нутгийн захиргааны байгаль хамгаалагч нарын зөвлөгөөн зохион байгуулах	2019 он	15,000.00	15,000.00
13	Идэвхтэн байгаль хамгаалагч, морин эргүүл ажиллуулах зардал /Бугат, Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Хангал, Тэшиг, Орхон/	2019 он	12,960.00	12,960.00
Дүн			978,129.9	978,129.9
Хоёр. Усны нөөцийг хамгаалах, усан хангамжийг сайжруулах талаар				
14	Булган сумын үерийн далан шинэчлэн засварлах /Булган сум 6-р хэсэг/	2018-2019 он	76,400.00	31,615.20
15	Орхон голын Зүр хүзүүний гарамд гатлага онгоц тавих	2018-2019 он	110,000.00	25,428.80
16	Рашаант сумын цэвэрлэх байгууламж	2018-2019 он	140,000.00	100,000.00
17	Хануйн голын Ангархайн замын засвар, шинэчлэлт	2019 он	467,000.00	467,000.00
18	Сайхан сумын төвт даралтат цамхаг барих	2019-2020 он	496,430.13	300,000.00
19	Цэцэрлэгүүдийн ариун цэврийн байгууламж барих /Хишиг-Өндөр, Сэлэнгэ сум/	2019 он	160,000.00	160,000.00
20	Эргийн бэхэлгээний ажлын зураг төсөл боловсруулах /Сэлэнгэ сум, Хутаг-Өндөр Хонгор баг/	2019 он	90,069.00	90,069.00
21	Усны тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулах	2019 он	8,000.00	8,000.00
22	Хульжийн рашааны ордын нөөцийг нарийвчлан тогтоох /Могод сум/	2019 он	200,000.00	200,000.00
23	Булаг шандын эх болон хүн амын усан хангамжийн худагт эрүүл ахуйн бүсийн хамгаалалтын хашаа барих ажлын жишиг зураг, төсөл боловсруулах	2019 он	600.00	600.00
24	Хүн амын усан хангамжийн худагт эрүүл ахуйн шаардлага хангасан ус нөөцлөх сав суурилуулах /5 ш, Сэлэнгэ, Баяннуур, Орхон, Гурванбулаг, Бүрэгхангай/	2019-2020 он	16,500.00	16,500.00

25	Баяннуурыг сэргээх зураг, төсөл боловсруулах /Баяннуур сум/	2019 он	32,000.00	32,000.00
26	Усан хангамж, ариутгах татуурга, төвлөрсөн шугам, сүлжээний ажлын зураг, төсөв боловсруулах /Баяннуур, Дашинчилэн, Гурванбулаг, Рашаант/	2019-2020 он	841,300.00	386,700.00
27	Хүн ам болон бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зориулалтаар шинээр инженерийн хийцтэй худаг гаргах /12 ш/	2019 он	204,000.00	204,000.00
28	Хутаг-Өндөр суманд үерийн далан барих	2019-2020 он	1,621,662.50	691,444.90
29	Сав газруудын талуудын оролцооны зөвлөлийн хурал, зөвлөгөөн	2019 он	15,000.00	15,000.00
30	Ногоон хөгжлийн бодлогын дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээ /1.Ногоон хөгжлийн хэтийн зорилт, 2. Агаарын бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр, 3.Аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр, 4. Хүүхэд залуучуудын экологийн боловсрол олгох дэд хөтөлбөр, 5.Жимс жисгэнэ хөтөлбөр, 6. Хатуу хог хаягдлын менежментийн мастер төлөвлөгөө, 7. У ариутгах татуургыг хөгжүүлэх бодлого, 8. Эрчим хүчний хэмнэлтийн бодлого, 9. Ойн талаар баримтлах бодлого, 10.Ус үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн бодлого/	2019 он	150,000.00	150,000.00
31	Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийн хяналт шалгалт	2019 он	38,000.00	38,000.00
32	Хануй голын сав газрын хамгаалалтын бүс тогтоох	2019 он	10,000.00	10,000.00
33	Хөвсгөл нуур- Эгийн голын сав газрын хамгаалалтын бүс тогтоох	2019 он	10,000.00	10,000.00
34	Сэлэнгэ голын сав газрын хамгаалалтын бүс тогтоох	2019 он	10,000.00	10,000.00
35	Орхон Чулуут голын сав газрын хамгаалалтын бүс тогтоох	2019 он	10,000.00	10,000.00
36	Туул голын сав газрын хамгаалалтын бүс тогтоох	2019 он	10,000.00	10,000.00
Дүн			4,716,961.6	2,966,357.9
Гурав. Газар, газрын хэвлийг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах, хог хаягдлыг багасгах талаар				
37	Бага оврын эксковатор /Булган сум/	2018-2019 он	85,000.00	85,000.00
38	Үлийн цагаан оготной тэмцэх ажил 62500 га	2018-2019 он	100,000.00	100,000.00
39	Булган сумын гэр хорооллын айл өрхөд хог төрөлжүүлэн хийх хогийн саваар нийлүүлэх /833 ш/	2019 он	416,500.00	416,500.00
40	“Цэвэр орчин” аяныг 16 сум, 1 тосгонд зохион байгуулах	2019 он	17,000.00	17,000.00
41	Доройтсон бэлчээрийг зайнаас тандан судлах, нөхөн сэргээх, туршилт судалгааны төв барих	2019 он	300,000.00	300,000.00
42	Бүх төрлийн зургийг хэвлэх plottoг хэвлэгч худалдан авах /ГХБХБГ/	2019 он	17,400.00	17,400.00
43	Багийн хилийн цэсийг тодорхойлох /16 сум/	2019 он	13,820.00	13,820.00
44	Газрын хэвлий, хөрсөнд учруулсан хохирлыг мэргэжлийн байгууллагаар байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох	2019 он	30,000.00	30,000.00

45	Хог хаягдлын цэгийг дарж булах, өөр газар шилжүүлэх /Хутаг-Өндөр сумын Хантай баг/	2019 он	27,000.00	27,000.00
46	Хог хаягдлын цэгийг дарж булах, өөр газар шилжүүлэх /Хутаг-Өндөр сумын Хонгор баг/	2019 он	20,000.00	20,000.00
47	Хог хаягдлын цэгийг дарж булах, өөр газар шилжүүлэх /Хангал сумын Хялганат тосгон	2019 он	25,000.00	25,000.00
48	Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдээр иргэдэд зориулсан сургалт сурталчилгаа, эко уралдаан зохион байгуулах /5 удаа/	2019 он	10,000.00	10,000.00
49	Хог хаягдлын улсын тоо бүртгэл, норм норматив тогтоох ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах, тооллого хийх	2019 он	7,500.00	7,500.00
50	Булган сумын агаарын бохирдлын явуул судалгааны агаараас дээж авагч мини памп авах	2019 он	9,000.00	9,000.00
51	Хөрсний шинжилгээний боловсруулалтад хэрэглэгдэх хөрсний автомат сэгсрэгч худалдан авах	2019 он	1,000.00	1,000.00
52	Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажилд дэмжлэг үзүүлэх	2019 он	40,000.00	40,000.00
53	Аялал жуулчлалын цогцолборын үргэлжлэл	2018-2019 он	250,000.00	250,000.00
54	Аялал жуулчлалын цогцолборын II шатны дуусгалын зураг төсөл	2019 он	50,000.00	50,000.00
Дүн			1,419,220.0	1,419,220.0
Дөрөв. Биологийн төрөл зүйлийг хамгаалах				
55	Тусгай хамгаалалттай газар нутагт биотехникийн арга хэмжээ авах /Зэд-Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газар, Хөгнө-Тарны тусгай хамгаалалттай газар/	2019 он	6,000.00	6,000.00
56	Ховор ургамал болох "Заан хүж"-ийг хамгаалах /Баян-Агт сум/	2019 он	3,000.00	3,000.00
57	Аймгийн хэмжээнд ерөнхий агнуур зохион байгуулалт хийлгэх	2019 он	30,000.00	30,000.00
58	Үйл ажиллагааны зардал	2019 он	4,000.00	4,000.00
Дүн			43,000.0	43,000.0
Нийт дүн			7,157,311.5	5,406,707.8

6.3 Засгийн газрын тусгай зориулалтын шилжүүлэг

Төсвийн ерөнхийлөн захирагч, аймгийн Засаг даргатай Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг байгуулсны үндсэн дээр сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, соёлын үйлчилгээ, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, газрын харилцаа кадастр, хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ гэсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Тусгай зориулалтын шилжүүлэг хэлбэрээр Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлж, тусгайлан тогтоосон зориулалт, нөхцөл, шаардлагын дагуу 2019 оны аймаг, сумын төсөвт тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагад 30,2 тэрбум, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, урсгал засварын зардалд 5,5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөлөө.

Эдгээр байгууллагуудын төсвийг боловсруулахдаа

- Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан тусгай зориулалтын шилжүүлгийн гэрээнд тусгагдсан үйлчилгээний стандарт, тоо хэмжээ, чанар, хүртээмжийг бууруулахгүй байхаар тооцлоо.
- Төсвийн төслийг холбогдох салбарын норм, норматив, статистик тоон үзүүлэлтэнд үндэслэн төсвийг хуваарилсан. /сурагчдын тоо, эмчлүүлэгчдийн орны тоо, өрхийн эрүүл мэндийн төвийн нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн хэмжээ гэх мэт/,

Сумын төсөвт тусгай зориулалтын шилжүүлгээр 34,4 тэрбум төгрөг хуваарилагдсан.

6.4. Орон нутгийн 2019 оны төсвийн үндсэн үзүүлэлтүүд

Аймгийн төсвийн 2019 оны орон нутгийн төсвийн нийт орлого болон зарлага 59,7 тэрбум төгрөг болж, 2018 оноос 3,4 тэрбум төгрөгөөр өсч байна.

Орон нутгийн төсвийн орлогын эх үүсвэрээр нь авч үзвэл,

1. Орон нутгийн төсвийн суурь орлого 23,1 тэрбум төгрөг
2. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 1,3 тэрбум төгрөг
3. Улсын төсвөөс олгох ОНХС-ийн шилжүүлгийн орлого 3,6 тэрбум төгрөг
4. Улсын төсвөөс орон нутагт олгох тусгай зориулалтын шилжүүлгээс 30,2 тэрбум төгрөг
5. Орон нутгийн төсвийн оны эхний үлдэгдэл 1,5 тэрбум

Орон нутгийн зарлагын бүрэлдэхүүнээр нь авч үзвэл,

6. Аймгийн төсөв 11,7 тэрбум
7. Сумын төсөв 7,2 тэрбум
8. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 1,1 тэрбум
9. Тусгай зориулалтын шилжүүлгийн зардал 36,1 тэрбум
10. Орон нутгийн хөгжлийн сан 3,6 тэрбум төгрөг байна.

ДОЛОО. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН ТӨСВИЙН БАГЦ**7.1 Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын төсөв**

Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн даргын төсвийн багцын урсгал зардлыг 492.0 сая төгрөгөөр тооцож төсөвлөв. Төсвийн төслийг байгууллагын ирүүлсэн санал болон 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэлд боловсрууллаа.

Төсвийн төслийг боловсруулахдаа байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах, төсвийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг дээшлүүлэх, төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээг бүрэн гүйцэтгэх зарчмыг баримтлан төлөвлөж, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа гэсэн хөтөлбөрт хуваарилан санхүүжүүлэхээр тооцлоо.

Хүснэгт №18.

Хөтөлбөрийн зардлын хураангуй

/мян. төг/

Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга	2017оны гүйцэтгэл	2018 оны ХБГ	2019 он			
			Урсгал зардал	Цалин, ндш	Бараа үйлчилгээ ний бусад	Татаас урсгал шилжүүлэг
Хөтөлбөрүүдийн нийт дүн	346,473.9	450,287.7	491,994.6	178,324.3	223,420.3	90,250.0
Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	296,528.3	386,737.7	405,994.6	178,324.3	137,420.3	90,250.0
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	49,945.6	63,550.0	86,000.0		86,000.0	

7.2 Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын төсөв

Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын төсвийн багцын 2019 оны урсгал төсвийг 2224,6 сая төгрөгөөр тооцож, орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлагыг хэрэгжүүлэх хөтөлбөрөөр төсөвлөж, байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах, төсвийг хэмнэлттэй үр ашигтай зарцуулах, үр өгөөжийг дээшлүүлэх, төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээг бүрэн гүйцэтгэхээр тооцсон болно.

Хүснэгт №19.

Хөтөлбөрийн зардлын хураангуй

/мян. төг/

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга	2017оны гүйцэтгэл	2018 оны ХБГ	2019 он			
			Урсгал зардал	Цалин, ндш	Бараа үйлчилгээний бусад	Татаас урсгал шилжүүлэг
Хөтөлбөрүүдийн нийт дүн	2,297,772.1	2,463,445.3	2,224,577.5	922,637.7	1,114,721.2	187,218.6
Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2,297,772.1	2,463,445.3	2,224,577.5	922,637.7	1,114,721.2	187,218.6

Ажиллагсадтай холбогдсон цалин, хөлсний зардалд 922,6 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1114,7 сая төгрөг, татаас урсгал шилжүүлэгт 187,2 сая төгрөг төлөвлөсөн.

Хөгжлийн хөтөч мөрийн хөтөлбөрт туссан дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зардалд 350,0 сая, техник хяналтын зардлыг 25,0 сая төгрөгөөр төлөвлөж, аймгийн Засаг даргын ангилагдаагүй бусад арга хэмжээний зардалд тусгалаа.

7.3. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын төсөв

Орон нутгийн өмчийн газрын даргын төсвийн урсгал зардлыг 116,6 сая төгрөгөөр төсөвлөсөн бөгөөд орон нутгийн төсвөөс 108,6 сая төгрөгийн санхүүжилт авч, тендерийн бичиг баримт худалдан борлуулснаас олох орлогын төлөвлөгөө 8,0 сая төгрөгөөр тооцолсон.

Хүснэгт №20.	Хөтөлбөрийн зардлын хураангуй			/мян. төг/		
	Орон нутгийн өмчийн газрын дарга	2017оны гүйцэтгэл	2018 оны ХБГ	2019 он		
Урсгал зардал				Цалин, ндш	Бараа үйлчилгээний бусад	Татаас урсгал шилжүүлэг
Хөтөлбөрүүдийн нийт дүн	86,990.8	97,797.9	116,660.9	94,090.3	21,570.6	1,000.0
Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	86,990.8	97,797.9	116,660.9	94,090.3	21,570.6	1,000.0

Дээрх төсвөөр төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар нийт 8 хүний орон тоотойгоор ажиллахаар тооцсон бөгөөд, урсгал зарлагын шинэчлэлтэй холбоотой нэмэгдлийг бүрэн тусгаж, 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэлтэй харьцуулахад 19,2 хувиар өссөн байна.

7.4 Аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын төсөв

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын төсвийн багцыг 454,2 сая төгрөгөөр төсөвлөж, хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн хүрээнд санхүүжүүлнэ.

Хүснэгт №21.	Хөтөлбөрийн зардлын хураангуй			/мян. төг/		
	Байгаль орчин аялал, жуулчлалын газрын дарга	2017оны гүйцэтгэл	2018 оны ХБГ	2019 он		
Урсгал зардал				Цалин, ндш	Бараа үйлчилгээний бусад	Татаас урсгал шилжүүлэг
Хөтөлбөрүүдийн нийт дүн	409,715.4	454,185.8	517,689.6	422,438.1	76,400.4	18,851.1
Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	409,715.4	454,185.8	517,689.6	422,438.1	76,400.4	18,851.1

Аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газрын 2019 оны урсгал төсвийн багцын хэмжээ 517,7 сая төгрөг, үүнээс нэг мэргэжилтэнд тэтгэвэрт гарахад олгох

нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардал 15,4 сая, бусад ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулалын зардал 3,4 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны бусад зардал 498,8 сая төгрөг тооцож тусгасан.

7.5 Санхүүгийн хяналт аудитын албаны даргын төсөв

Тус алба нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, зөвлөмж гаргах, эрсдлийн удирдлагаар хангаж тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Үйл ажиллагааны зардалд 2019 онд 122.6 сая төгрөгийн санхүүжилт олгож үндсэн чиг үүргээ хэвийн явуулах хэмжээнд урсгал зардлыг тооцлоо.

Хүснэгт №22.		Хөтөлбөрийн зардлын хураангуй			/мян. төг/	
Санхүүгийн хяналт, аудитын газрын дарга	2017оны гүйцэтгэл	2018 оны ХБГ	2019 он			
			Урсгал зардал	Цалин, ндш	Бараа үйлчилгээ ний бусад	Татаас урсгал шилжүүлэг
Хөтөлбөрүүдийн нийт дүн	88,799.7	116,831.2	122,649.6	92,751.0	28,898.6	1,000.0
Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	88,799.7	116,831.2	122,649.6	92,751.0	28,898.6	1,000.0

Зардлын бүтцийн хувьд 75,6 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлд, 23,6 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд, 0,8 хувийг татаас урсгал шилжүүлгийн зардалд зарцуулахаар төлөвлөв.

7.6 Хүүхдийн сувиллын эрхлэгчийн төсөв

Хүүхдийн сувиллын даргын төсвийг 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 9,0 сая төгрөг нэмэгдүүлэн 131,2 сая төгрөгөөр тооцсон нь байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах, ажиллагсдын нийгмийн баталгааг ханган тайлант жилд өр авлага үүсэхгүй байхаар төлөвлөсөн болно.

Хүснэгт №23.		Хөтөлбөрийн зардлын хураангуй			/мян. төг/	
Хүүхдийн сувилалы яслийн эрхлэгч	2017оны гүйцэтгэл	2018 оны ХБГ	2019 он			
			Урсгал зардал	Цалин, ндш	Бараа үйлчилгээ ний бусад	Татаас урсгал шилжүүлэг
Хөтөлбөрүүдийн нийт дүн	116,274.5	122,199.4	131,179.7	78,463.9	47,729.8	4,986.0
Нийгмийн халамж, хамгаалал	116,274.5	122,199.4	131,179.7	78,463.9	47,729.8	4,986.0

7.7 Биеийн тамир спортын газрын даргын төсөв

Нийтийн биеийн тамирын үйлчилгээг Төсвийн ерөнхийлөн захирагч, аймгийн Засаг даргатай Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаардаг байсан ч 2019 оноос чиг үүргийг орон нутаг бие даан хэрэгжүүлэхээр болсон.

Хүснэгт №24	Хөтөлбөрийн зардлын хураангуй		/мян. төг/			
	2017оны гүйцэтгэл	2018 оны ХБГ	2019 он			
Биеийн тамир спортын газрын дарга			Урсгал зардал	Цалин, ндш	Бараа үйлчилгээний бусад	Татаас урсгал шилжүүлэг
Хөтөлбөрүүдийн нийт дүн	579,094.9	645,111.9	833,301.6	263,947.7	560,753.9	8,600.0
Биеийн тамир спорт	579,094.9	645,111.9	833,301.6	263,947.7	560,753.9	8,600.0

Биеийн тамир спортын газар нь Спорт хороо, Усан спорт сургалтын төв, Хялганат тосгоны спорт цогцолборын үйл ажиллагааг 30 орон тоотойгоор хариуцан явуулна.

Урсгал төсвийн 31,7 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэл, 59,3 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 9,0 хувийг бусад бараа үйлчилгээний зардал эзэлж байна.

7.8 Соёлын байгууллагуудын төсөв

Соёл, урлагийн салбарт 2019 оны төсвийн жилд 20 байгууллага 189 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулахаар тооцож 2284,7 сая төгрөг төсөвлөлөө. Үүнийг 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэлтэй харьцуулахад 227,6 сая төгрөгөөр өсөж байна.

Нэгдсэн халаалтад холбогдсон Рашаант, Хялганат тосгон, зарим байгууллагуудын халаалт, дулааны зардлыг нэмэгдүүлээгүй ирснийг орон нутагт шилжин ирсэн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын тогтмол зардалд багтаан өр төлбөр үүсгэхгүй байхаар төлөвлөлөө.

Хүснэгт №24	Хөтөлбөрийн зардлын хураангуй		/мян. төг/			
	2017оны гүйцэтгэл	2018 оны ХБГ	2019 он			
Соёлын салбар			Урсгал зардал	Цалин, ндш	Бараа үйлчилгээний бусад	Татаас урсгал шилжүүлэг
Хөтөлбөрүүдийн нийт дүн	2,003,814.1	2,056,915.5	2,284,759.8	1,671,326.2	601,006.1	12,427.5
Соёл, урлаг	2,003,814.1	2,056,915.5	2,284,759.8	1,671,326.2	601,006.1	12,427.5

Соёл урлагийн хөтөлбөрийн урсгал зардлын 73,1 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэл, 26,3 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 0,6 хувийг татаас урсгал шилжүүлгийн зардал эзэлж байна.

НАЙМ. ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛГИЙН БАЙГУУЛЛАГЫН УРСГАЛ ТӨСВИЙН ТАНИЛЦУУЛГА

8.1 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцын төсвийн танилцуулга

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд нь сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, насан туршийн боловсрол олгох эрхийг орон нутагт шилжүүлэн 24,3 тэрбум төгрөгийн орлогын шилжүүлэг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал /гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир ус/, урсгал засварын зардалд 3,9 тэрбум төгрөгийг орон нутгийн суурь зардалд тусган эрхээ шилжүүлсэн байна.

8.1.1 Ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээ

Ерөнхий боловсролын сургуулиудын төсвийг 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэн 20.3 тэрбум төгрөгөөр тооцсон ба үүний 71.9 хувийг багш, ажилчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэлд, 24,9 хувийг бараа үйлчилгээний зардалд, 3,0 хувийг татаас урсгал шилжүүлгийн зардалд зарцуулахаар төлөвлөсөн.

Хүснэгт №24. Хөтөлбөрүүдийн зардлын хураангуй /сая төгрөг/

Ерөнхий боловсролын сургууль	2017оны гүйцэтгэл	2018 оны ХБГ	2019 он			
			Урсгал зардал	Цалин, ндш	Бараа үйлчилгээний бусад	Татаас урсгал шилжүүлэг
Хөтөлбөрүүдийн нийт дүн	14,364.6	16,814.7	20,298.9	14,631.7	5,059.8	607.4
Ерөнхий боловсрол	14,305.1	16,768.8	20,230.7	14,571.3	5,052.1	607.3
Насан туршийн болон албан бус боловсрол	59.5	45.9	68.2	60.4	7.7	0.1

2019 онд ерөнхий боловсролын 23 сургуульд 10.0 мянган сурагч суралцаж байгаа ба нийт 1175 багш, ажилтан ажиллахаар тооцож 15 орон нэмэгдсэн нь сумын санхүүгийн албанд өөрчлөлт орж, байгууллагын нягтлан бодогч цалингийн сан, орон тоотойгоо шилжиж ирсэнтэй холбоотой байна.

8.1.2 Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ

Аймгийн хэмжээнд 22 цэцэрлэгт 435 багш ажилтан ажиллаж, 4,3 мянган хүүхэд хүмүүжиж байна. Тус хөтөлбөрийн урсгал зардалд 7,0 тэрбум төгрөг төлөвлөсөн нь өмнөх оноос 0,2 сая төгрөгөөр өслөө.

Хүснэгт №25. Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн хураангуй /сая.төг/

Хүүхдийн цэцэрлэг	2017оны гүйцэтгэл	2018 оны ХБГ	2019 он			
			Урсгал зардал	Цалин, ндш	Бараа үйлчилгээний бусад	Татаас урсгал шилжүүлэг
Хөтөлбөрүүдийн нийт дүн	5,508.4	6,326.0	7,856.4	5,728.9	2,113.3	14.2
Сургуулийн өмнөх боловсрол	5,508.4	6,326.0	7,856.4	5,728.9	2,113.3	14.2

Булган сумын 2-р цэцэрлэгийн 1 бүлэг нь 24 цагийн үйл ажиллагаатай тул эмчийн зардлыг нэмж,Хутаг-өндөр сумын цэцэрлэг нь сумын төвдөө 7 бүлэгтэй Хонгор, Уньт,Хантай багуудад тус бүр нэг нэг цэцэрлэгтэй санхүүгийн хувьд ажиллагаа ихтэй тул 1 нягтлан бодогч, мөн Булган сумын 1,4,6,7-р цэцэрлэгүүд нь нэг сахиултай ауиллаж байсныг 3 ээлжийн жижүүртэй болгохоор тус бүр хоер хүн нэмэхээр тооцон 8 орон тоог нэмж тусгалаа.

Катар улсын санхүүгийн дэмжлэгтэйгээр шинээр баригдах Булган сумын 5-р цэцэрлэгийн үйл ажиллагааны зардлыг тооцож тусгасан. Мөн Аймгийн ЗДТГ-ын байранд байгуулагдах байгууллагын дэргэдэх 75 хүүхдийн цэцэрлэгийн урсгал зардлыг тооцон төлөвлөлөө.

8.2 Эрүүл мэндийн сайдын багцын төсвийн танилцуулга - Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ

2019 оны Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг нь “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль”-ийн 17-р зүйлд заасны дагуу шинэ аргачлалаар боловсруулагдаж батлагдсан бөгөөд суурь тусламж, үйлчилгээг нэг иргэнээр тооцсон төлбөрийн аргаар, Эрүүл мэндийн даатгал болон хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар санхүүжүүлнэ.

Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн төсвийг Эрүүл мэнд, Сангийн сайдын 2015 оны 12 дүгээр сарын 21-ны өдрийн 498/345 тоот хамтарсан тушаал /Сум, тосгоны Эрүүл мэндийн төвийн санхүүжилтийн аргачлал батлах тухай/-ыг баримтлан боловсруулж, хуваарилсан.

Сумын Эрүүл мэндийн төвүүдийн нийт санхүүжилтийн 64,0% цалин, Нийгмийн даатгалын шимтгэл, 8,9 хувь нь тогтмол зардалд, 27,1% нь бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ	2017оны гүйцэтгэл	2018 оны ХБГ	Хүснэгт №27. Хөтөлбөрийн зардлын хураангуй /сая.төг/			
			2019 он			
			Урсгал зардал	Цалин, ндш	Бараа үйлчилгээн ий бусад	Татаас урсгал шилжүүлэг
Хөтөлбөрүүдийн нийт дүн	4,373.0	4,364.5	5,761.5	3,689.5	2,059.4	12.6
Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	4,213.2	4,191.1	5,567.4	3,689.5	1,865.3	12.6
Нийгмийн эрүүл мэнд	159.8	173.4	194.0	-	194.0	-

Эрүүл мэндийн төвүүдэд тайлант онд нийт 312 төрийн албан хаагч ажиллах бөгөөд, сумын санхүүгийн албаны бүтэц орон тоонд өөрчлөлт орж, нэг нягтлан бодогч орон тоо, цалингийн сантайгаа сумын эрүүл мэндийн төвд шилжин ирсэн.

8.3 Хөдөлмөр, нийгмийн хамааллын сайдын багцын төсвийн танилцуулга-Гэр бүл, хүүхэд, залуучуудын үйлчилгээ

Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргын төсвийн багцыг 290,8 сая төгрөгөөр төлөвлөж, нийгмийн хамгааллын бодлого удирдлага хөтөлбөрийн хүрээнд санхүүжүүлнэ.

Хүний хөгжлийн төвийг тус байгууллагын өмчлөлд шилжүүлсэнтэй холбоотойгоор гэрээгээр гүйцэтгэх ажилтны цалин, нийгмийн даатгалын зардал, ордны тогтмол зардал, хүүхэд хамгааллын үйлчилгээний хөтөлбөрийн санхүүжилт зэргийг бүрэн тусгаж өгсөн.

Хүүхэд хамгааллын чиглэлээр сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажил, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор 62,0 сая төгрөгийг тусгасан нь хүчирхийлэлд өртсөн хүүхэд, гэр бүлд очиж үйлчилгээ үзүүлэх нөхцлийг бүрдүүлж байна.

Хүснэгт №29. Хөтөлбөрийн зардлын хураангуй /сая.төг/

Орон нутгийн хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгаалал	2017оны гүйцэтгэл	2018 оны ХБГ	2019 он			
			Урсгал зардал	Цалин, ндш	Бараа үйлчилгээний бусад	Татаас урсгал шилжүүлэг
Хөтөлбөрүүдийн нийт дүн	162.4	222.9	290.8	90.7	193.6	6.5
Нийгмийн хамгааллын бодлого, удирдлага	162.4	222.9	290.8	90.7	193.6	6.5

Нийт урсгал зардлын 31.2 хувийг цалин нийгмийн даатгалын шимтгэлд, 66,6 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд, 2,2 хувийг татаас урсгал зардалд зарцуулна.

8.4 Барилга, хот байгуулалтын сайдын багцын төсвийн танилцуулга - Газрын харилцаа, геодези зураг зүй, барилга хот байгуулалтын үйлчилгээ

Газрын харилцаа, геодези зураг зүй, барилга хот байгуулалтын чиглэлээр 2019 онд 484,0 сая төгрөг тусгаж, уг төсөвт багтаан төрийн үйлчилгээг иргэд олон нийтэд хүртээмжтэй, ил тод шударга хүргэхээр төлөвлөж байна.

Хүснэгт №30. Хөтөлбөрийн зардлын хураангуй /сая.төг/

Газар, зохион байгуулалт, барилгын техник хяналт	2017оны гүйцэтгэл	2018 оны ХБГ	2019 он			
			Урсгал зардал	Цалин, ндш	Бараа үйлчилгээний бусад	Татаас урсгал шилжүүлэг
Хөтөлбөрүүдийн нийт дүн	241.1	378.5	484.0	379.8	81.5	22.7
Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуй, газрын баталгаажуулалт	241.1	378.5	484.0	379.8	81.5	22.7

Төсвийн зарлагын дийлэнх буюу 78,5 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 16,8 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 4,7 хувийг татаас урсгал шилжүүлгийн зардал эзэлж байна.

Аймгийн 2018 оны төсвийн тооцооллыг хавсаргав.